

ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ НАРЫН 2025 ОНЫ ХӨТӨЛБӨР, АРГА ХЭМЖЭЭНД ЗАРЦУУЛСАН ТӨСӨВ ХҮРСЭН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

№	Хөтөл-бөрийн код	Хөтөлбөрийн нэр	Батлагдсан төсөв	Төсвийн гүйцэтгэл	Төсвийн гүйцэтгэлийн %	Хөтөлбөрийн үр дүнгийн шалгуур үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Суурь он	Суурь түвшин	2025 оны зорилтот түвшин	Хүрсэн түвшин	Тайлбар	Аймаг
<b>АРХАНГАЙ АЙМАГ</b>													
1	70105	Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын үйл ажиллагаа	6,167,045.0	5,436,547.3	88.15%	Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын үйл ажиллагааны хувь	хувь	2024	Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын үйл ажиллагаа хэвийн, жигд байдал хангагдсан	100	88.2	Нутгийн өөрөө удирдах байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг хангаж ажиллахад ИТХ-ын байгууллагаас 2025 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг 6 үндсэн зорилтын хүрээнд 47 арга хэмжээг төлөвлөн батлуулж хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр тооцон ажилласнаар төлөвлөгөөний биелэлт 88.15%-ийн биелэлтэй хэрэгжсэн байна. Тайлант жилд иргэдийн Төлөөлөгчдийн Хурал ээлжит 4, 5, 6, 8 ээлжит бус 7, 9 нийт 6 удаа хуралдаж асуудлыг хэлэлцэн баталсан байна. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 03/04 дугаар тогтоолоор аймгийн иргэдийн төлөөлөгчдийн Хурлын 2025 оны төсвийг баталсан байна.	Архангай
2	70106	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	44,652,494.2	38,658,814.5	86.58%	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын хувь	хувь	2024	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын байгууллагын үйл ажиллагаа хэвийн жигд байдал хангагдсан	100	86.6	Төрийн захиргааны удирдлагын манлайллыг хэрэгжүүлэх, хууль, эрх зүй, хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлт, санхүү, төсөв, нийгмийн бодлого, хяналт-шияжиглээ, үнэлгээ, батлан хамгаалах чиглэлээр 44 зорилтын хүрээнд 131 арга хэмжээг 86.58 хувьтай хэрэгжүүлж ажилласан.	Архангай
3	70417	Мэргэжлийн хяналт	536,251.6	514,795.5	96.00%	Эрсдэлд суурилсан аудит, хяналт шалгалтад хамрагдсан объектын тоо	тоо	2024	56	46	54.0	2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу хуулиар олгосон тусгайлсан болон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн зорилт нийт 7 бац 28 ажил арга хэмжээг хэрэгжүүлж, удирдлага зохион байгуулалтаар ханган ажиллалаа. Тайлангийн хугацаанд нийтдээ 86 байгууллагад аудит, хяналт шалгалт хийгдсэн. Байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу дотоод аудит, хяналт шалгалтыг төлөвлөгөөт 50, удирдах дээд байгууллагын шийдвэрээр-1, төлөвлөгөөт бус 35, нийт 86 байгууллагын үйл ажиллагааг хамруулан хийж, үнэлэлт дүгнэлт өгч аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн Дотоод аудитын хороонд танилцуулсаны зэрэгцээ ахиж сайжруулах чиглэлээр Дотоод аудитын хорооны зөвлөмж болон Дотоод аудиторын зөвлөмжүүдийг бэлтгэн харилцаж байгууллагын төсөв захирагч нарт хүргүүлж, биелэлтийг тооцон ажиллалаа. Дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтаар 4,924.0 сая төгрөгийн зөрчил илрүүлж, улсын байцаагчийн 143 актаар 841.2 сая төгрөгийн нөхөн төлбөр тогтоож, тайлант хугацаанд 322.0 сая төгрөгийн нөхөн төлбөрийг барагдуулсан. Улсын байцаагчийн 62 албан шаардлагаар 4,082.8 сая төгрөгийн зөрчил арилгуулах хугацаатай үүрэг өгч, биелэлтийг хангуулан ажиллаж байна. 2025 оны жилийн эцсийн байдлаар улсын байцаагчийн актын биелэлт 62.1%, албан шаардлагын биелэлт 99.1% -тай гарлаа.	Архангай
						Илрүүлсэн төлбөр зөрчлийн дүн	тоо	2024	810	545.6	684.3		Архангай
4	70418	Худалдан авах ажиллагаа	347,386.1	261,183.9	75.19%	Аймгийн ТЕЗ-ийн харьяаны төсөвт албан газар, орон нутгийн өмчит байгууллагуудын нийт худалдан авалтад эзлэх цахим худалдан авалтын хувь	хувь	2024	85	90	100.0	2025 онд Улсын төсвийн хөрөнгө оруулалт байхгүй. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 03/04 дүгээр тогтоолоор баталсан 2025 онд Орон нутгийн хөгжлийн сан, орон нутгийн төсөв, авто замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх нийт 15,222.3 сая төгрөгийн өртөг бүхий 35 төсөл арга хэмжээг баталлаа. Үүнд Орон нутгийн хөгжлийн сангаар 7,151.4 сая төгрөгийн 17 төсөл арга хэмжээ, орон нутгийн төсвийн 6,595.5 сая төгрөгийн 17 төсөл арга хэмжээ, авто замын сангийн 1,475.4 сая төгрөгийн 1 төсөл арга хэмжээ батлагдсан. Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлж аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас 2,365.6 сая төгрөгийн 5 төсөл арга хэмжээний тендер шалгаруулалтыг зогсоож хэрэгжээгүй. Төсвийн ерөнхийлөн захирагч 1,300.0 сая төгрөгийн 4 төсөл арга хэмжээний тендер шалгаруулалтыг тухайн нутаг дэвсгэрийн төсвийн ерөнхийлөн захирагчид эрхийг шилжүүлэх шийдвэр гарган ажилласан.	Архангай
5	70426	Төрийн өмчийн эрхийг хэрэгжүүлэх	458,322.5	237,783.6	51.88%	Орон нутгийн өмчид бүртгэлтэй, ашиглалтгүй үл хөдлөх хөрөнгийн тоо	тоо	2024	25	10	10.0	Аймгийн ИТХ-аар орон нутгийн өмчтэй холбоотой 18 тогтоол гарч хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Орон нутгийн өмчтэй 177 байгууллагын өмч эзэмшүүлэх гэрээг дүгнэх ажлыг 87 байгууллагатай өмч эзэмшүүлэх гэрээг байгуулж ажиллаа. аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2025 оны 03 дугаар сарын 31-ны өдрийн 04/07, 2025 оны 6 дугаар сарын 26-ны өдрийн 05/21, 2025 оны 6 дугаар сарын 26-ны өдрийн 05/21 тогтоолуудаар Орон нутгийн өмчид 13 үл хөдлөх хөрөнгийг үндсэн хөрөнгийн бүртгэлд бүртгэж ажиллаа. Барилга үндсэн хөрөнгийн бүртгэлээс хасч, актлах тухай тогтоолоор 4 төсөв байгууллагын 4 ширхэг барилгыг акталж газар чөлөөлөх ажлыг зохион байгуулсан. Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журмыг 2025 оны 3 дугаар сарын 31-ны өдрийн 04/09 дүгээр тогтоолоор батлуулж батлуулж 177 орон нутгийн өмчтэй байгууллагуудад журмын эмхэтгэл гарган өгч мөрдүүлж ажиллаж байна. Эрчим хүчний дад станцыг төрийн өмчид шилжүүлэх тухай, Орон нутгийн өмчтэй 10 байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 23 дэд станцыг Төрийн өмчтэй цахилгаан түгээх байгууллагад шилжүүлэхээр Төрийн өмчийн бодлого зохицуулалт газарт холбогдох материал, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тогтоолын хамт хүргүүлсэн. 2025 онд орон нутгийн өмчтэй 6 байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 6 тээврийн хэрэгслийг данс хооронд шилжүүлж, хүлээлгэн өгсөн. 2025 оны 9 дүгээр сарын 29-ны өдрийн 07/35 дүгээр тогтоолоор тээврийн хэрэгсэл үндсэн хөрөнгийн бүртгэлээс хасгах тухай тээврийн хэрэгслийн дуудлагын худалдааг зохион байгуулж орон нутгийн өмчид бүртгэлтэй байсан 32 ширхэг автомашин худалдан борлуулснаар орон нутгийн төсөвт 79.9 төвлөрүүлсэн.	Архангай
6	70501	Орон нутгийн төсөвт олгох орлогын шилжүүлэг	14,919,454.4	10,891,401.6	73.00%	ОНХС-ийн хөрөнгө оруулалтын арга хэмжээг оновчтой төлөвлөх, хэрэгжүүлэх	хувь	2024	ОНХС-ийн хөрөнгө оруулалтын арга хэмжээг оновчтой төлөвлөх, хэрэгжүүлэх	100	100.0	2025 оны аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний загсаалтыг батлахдаа Төсвийн тухай хуулийн 60.3 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 86 дугаар тушаалын дагуу сум орон нутаг, олон нийтэд ил тод, нээлттэй хэлэлцүүлгийг зохион байгуулан саналыг цахим болон цаасан хэлбэрээр хүлээн авч үйл ажиллагааны хөтөлбөрт тусгаж, санал өгөх эрх бүхий иргэдийн оролцоог 100% ханган аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 03/04 дүгээр тогтоолоор 6,563 сая төгрөгийн төсөвтэй 17 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсан. 2025 онд 07 дугаар сарын 21-ний өдрийн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 06/28 дугаар тогтоолоор аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 17 төсөл арга хэмжээг 4,929.6 сая төгрөгөөр санхүүжихээр тодотгон баталсан. Үүнээс санхүүжилт удаашралтай байсантай холбогдулан хэрэгжээгүй 1 төсөл, хэрэгжиж дууссан 12 төсөл, 70-90 хувьтай үргэлжилж буй 4 төсөл арга хэмжээ байна. Аймгийн хэмжээнд энэ онд нийт ОНХС-ийн хөрөнгөөр 180 төсөл арга хэмжээг хэрэгжиж байгаагаас он дамжиж буй 8 төсөл, хэрэгжээгүй 18 төсөл, хэрэгжсэн 154 төсөл арга хэмжээний мэдээллийг ОНХС-ийн удирдлага мэдээллийн системд байршуулж тус сангийн үйл ажиллагаанд иргэд олон нийтийн хяналт тавих боломжийг бүрдүүлэн ажиллаж байна.	Архангай

№	Хөтөл-бөрийн код	Хөтөлбөрийн нэр	Батлагдсан төсөв	Төсвийн гүйцэтгэл	Төсвийн гүйцэтгэлийн %	Хөтөлбөрийн үр дүнгийн шалгуур үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Суурь он	Суурь түвшин	2025 оны зорилтот түвшин	Хүрсэн түвшин	Тайлбар	Аймаг
7	70801	Мал аж ахуйг хөгжүүлэх	1,246,558.4	1,236,800.0	99.22%	Урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хамруулах малын тоо	тоо	2025	1,477,000.00	1,477,000.00	1,477,000.00	Засгийн газрын 225 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан гоц халдварт, халдварт зооноос өвчнүүдээс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын арга хэмжээ. Үүнд: Галзуу өвчнөөс урьдчилан сэргийлэх төлөвлөгөөт дархлаажуулалтад аймгийн хэмжээнд 3,256 өрхийн 108,788 толгой бод, 29,191 толгой бод, 6,000 нохой нийт 143,979 мал, амьтан хамрагдаж 97.9%-тай дархлаажуулалтын ажил дууссан. Листерияс өвчнөөс урьдчилан сэргийлэх төлөвлөгөөт дархлаажуулалтад 8 сумын 53 малчин өрхийн 14131 хонь, 7819 ямаа, нийт 21,950 толгой бод мал хамрагдаж дархлаажуулалтын гүйцэтгэл 99.7%-тай дууссан. Боом өвчнөөс урьдчилан сэргийлэх төлөвлөгөөт дархлаажуулалтад 19 сумын 3,244 өрхийн 197,428 бод 49,629 бод нийт-247,057 мал хамрагдаж дархлаажуулалтын гүйцэтгэл 99.7%-тай жилийн эцсийн дархлаажуулалтын ажил бүрэн хийгдэж дууссан. Бруцеллэс өвчний дархлаажуулалтад 19 сумын тугал 141,710, хурга 471,302, ишиг 325,026 нийт 938,038 төл мал хамрагдахаас 3,239 өрхийн тугал-141,007, хурга-471771 ишиг 320,756 нийт 933,534 хамрагдаж, дархлаажуулалтын ажил 99.5 хувьтай ажил гүйцэтгэл дууссан. Гоц халдварт бог малын мялзан өвчний дархлаажуулалтыг Цэнхэр, Төвшрүүлэх, Хотонт, Хашаат, Өгийнуур, Өлзийт сумдын нийт 538,700 төл малыг хамруулахаар төлөвлөж 3,244 өрхийн 323,664 толгой хурга, 213,419 толгой ишиг нийт 537,083 толгой төл мал хамруулж заасан хугацаанд дархлаажуулалтыг зохион байгуулж ажлын гүйцэтгэл 99.8 хувьтай дууссан. Гоц халдварт Хонин цэцэг өвчний дархлаажуулалтыг Батцэнгэл, Төвшрүүлэх, Хотонт, Хашаат, Өгийнуур, Өлзийт сумдын 759,317 хонь 235,683 хурга нийт 982,500 толгой малыг хамруулахаар төлөвлөж 2,635 өрхийн хонь-738,560 хурга-241,493 нийт 980,053 төл мал хамруулж дархлаажуулалтын ажил 99.8% хувьтай ажлын гүйцэтгэл дууссан. Гоц халдварт бог малын мялзан өвчний дархлаажуулалтыг Жаргалант, Эрдэнэмандал, Цэцэрлэг, Хайрхан, Ихтамир, Эрдэнэбулган сумдын нийт 394,800 төл малыг хамруулахаар төлөвлөж 3,244 өрхийн 233,505 толгой хурга 160,223 толгой ишиг нийт 393,728 толгой төл мал хамруулж дархлаажуулалтын ажил 99.8 хувьтай ажлын гүйцэтгэл дууссан. Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд 9,657 өрхийн 563,667 үхэр, 186,045 тугал, 266 гахай нийт-749,978 толгой мал амьтан хамруулж 99.8 хувьтай ажлын гүйцэтгэл дууссан.	Архангай
						Вакцины тоо	тоо	2025		4	4.0	Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2025 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн А/68 дугаар тушаал, аймгийн Засаг даргын 2025 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн А/206 дугаар захирамж, Архангай аймгийн Мал эмнэлгийн газрын даргын 2025 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн А/17 дугаар тушаалын дагуу төлөвлөгөөт дархлаажуулалтын ажлыг зохион байгуулан сумдад шаардлагатай вакциныг технологиот хугацаанд хүргүүлж, мэргэжил арга зүй, заавар зөвлөмжөөр хангаж ажилсан. Биокамбинат ТӨУГазар нь 2025 онд Мал эмнэлгийн газрын даргатай байгуулсан гэрээнд тусгасан халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх төлөвлөгөөт дархлаажуулалтын вакциныг хугацаанд нь нийлүүлж чадахгүй, үйлдвэрлэлийн явц удааширсан тул Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх вакциныг Биокамбинат ТӨУГазраас нийт- 8 удаагийн татан авалтын хийсэн. 1. Цусан халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад аймгийн хэмжээнд 3,440 өрхийн 200,175 бод, 216 өрхийн 56,745 бод нийт 256,920 мал хамрагдаж дархлаажуулалтын гүйцэтгэл 95.1% -тай дууссан. 2. Дотрын халдварт хордлого өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад 19 сумын 3168 өрхийн 843,732 бод мал хамрагдаж дархлаажуулалтын гүйцэтгэл 99.2%-тай дууссан. 3. Дуут хавдар өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад 11 сумын 488 өрхийн 19,899 толгой бод мал хамрагдаж дархлаажуулалтын гүйцэтгэл 99.4%-тай дууссан. 4. Сахуу, шөвөг яр өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын вакциныг 100% татан авсан. М.л эмнэлгийн үйлчилгээний нэгжийн эмч нарт хуваарийн дагуу олгосон.	Архангай
8	71403	Ойжуулалт	860,601.4	819,387.1	95.21%	Ойн нөхөн сэргээлтийн ажил зохион байгуулсан талбай	га	2024	165	175	215.0	2024 онд ойн дагалт баялаг болох хуш модны самрыг үйлдвэрлэлийн зориулалтаар түүж ашигласан ААНБ-тай сум дундын ойн ангиудын хийсэн гэрээний дагуу ойжуулалтын ажлыг 80 га талбайд 130,500 ширхэг шинэсий 2-3 настай тарьцаар ойжуулалтын ажлыг хийлээ. Мөн Цэнхэр, Жаргалант сумын ой ашиглалтын мэргэжлийн байгууллагууд 50 га талбайд 100,000 ширхэг, Ихтамир сум орон нутгийн төсвийн хөрөнгөөр 35 сая төгрөгөөр 45 га талбайд байгалийн сэргэн ургалтад туслах ажлыг гүйцэтгэн намрын тооллогоор 105,298 ширхэг цухуйг ургасан байна.Улсын төсвийн хөрөнгөөр 40 га талбайд 76,000 ширхэг шинэсийн тарьцаар ойжуулалтын ажлыг нийт 215 га талбайд 386,500 ширхэг 2-3 настай тарьцаар ойжуулалтын ажлыг хийж гүйцэтгүүлээ.	Архангай
9	71411	Хүрээлэн буй орчны бодлого, удирдлага	1,678,692.0	1,563,260.0	93.12%	Ногоон байгууламжийн өсөлт	га	2024	178.5	16	25.0	"Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд БОГ, УБХэлтэс, ШШГГазар, Эрдэнэбулган сумын 1-р сургуулийн 1976 оны төгсөгчид ойн төгөл байгуулж шинээр болон нөхөн тарилт хийлээ. 17 суманд ойн зурвас, цэцэрлэгт хүрээлэнд мод тарьсан бол Хангай, Эрдэнэмандал, сумын 100 жилийн ойн нэрэмжит цэцэрлэгт хүрээлэн байгууллаа. Цэнхэр суманд уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ААНБ-ууд Хотонт суманд 3 га талбайд ойн зурвас байгуулж 3000 мод тарилаа. Аймгийн хэмжээнд 2025 онд давхардсан тоогоор 277 аж ахуйн нэгж, байгууллага, 12,261 иргэн 25 га талбайд 16 нэр төрлийн 61,103 ширхэг мод, бут, сөөгийг тарьж, усалгаа арчилгааг технологийн дагуу хийж гүйцэтгүүлээ.	Архангай
10	71502	Хот байгуулалт, тохижилт	1,575,894.1	1,575,894.1	100.00%	Төсөвт төвлөрүүлсэн төлбөрийн хэмжээ	төгрөг	2024		129	135.0	2025 оны жилийн эцсийн байдлаар Эрдэнэбулган сумын 6 багийн 6400 орчим түр болон байнгын оршин суугч айл өрхүүдээс хог тээврийн 6 автомашин, төв байр аж ахуй нэгжид 1 машин нийт 7 машин явж байгаа ба өдөрт дундаар 20-21 рейс хийж, нийт 105,000 тн хог хаягдалыг айл өрхөөс хаяж байна. Мөн аж ахуй нэгж байгууллагаас өдөрт 5-6 рейс бууц 20,000 тн хог хаягдлыг ажил тээвэрлэн нэгдсэн хогын цэгт хаяж байна. Ингээд сар болон жилийн хог хаягдлыг бодохоор сард 2,330,100 тн хог, жилдээ 27,960,200 тн хог тээвэрлэн нэгдсэн хогын цэгт хаяж, дарж бууширсан байна. 2025 онд хог хаягдлын гэрээгээр 6,400 айл өрх, 250 байгууллагатай хийж төсөвт 280.0 сая төгрөг төвлөрүүлэхээс 401.0 сая төгрөг төвлөрүүлсэн байна.	Архангай
	71601	Нийгмийн эрүүл мэнд	1,125,146.0	1,125,146.0	97.90%					100	100	Аймгийн эрүүл мэндийн салбарын нийт 115 байгууллагад 1,302 эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилтан ажиллаж, хүн амд эрүүл мэндийн анхан шатны болон лавлагаа шатлалын тусламж үйлчилгээг суурин хүн амд болон хөдөлгөөнт хүн амд харьяалал харгалзахгүй үзүүлж байна. 2025 онд аймгийн хэмжээнд давхардсан тоогоор 289.4 мянган иргэний эрүүл мэндийн үзлэгт хамруулснаас 93.5 мянган иргэнд урьдчилан сэргийлэх үзлэг хийсэн бөгөөд 0-2 насны хүүхдийн 99.6 хувийг дархлаажуулалтад хамруулсан байна. Аймгийн Нэгдсэн эмнэлгийн хуучин барилга, байгууламж, материаллаг бааз болон Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн лаборатори, техник, тоног төхөөрөмж, бусад нөөцөд түлгүрлэн	Архангай

№	Хөтөл-бөрийн код	Хөтөлбөрийн нэр	Батлагдсан төсөв	Төсвийн гүйцэтгэл	Төсвийн гүйцэтгэлийн %	Хөтөлбөрийн үр дүнгийн шалгуур үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Суурь он	Суурь түвшин	2025 оны зорилтот түвшин	Хүрсэн түвшин	Тайлбар	Аймаг
11	71602	Эмнэлгийн тусламж үйлчилгээ	1,755,429.4	1,554,124.8	97.90%	Сумын эрүүл мэндийн төвүүдийн үйл ажиллагааны хэвийн жигд байдал	хувь	2024	Сумын эрүүл мэндийн төвүүдийн үйл ажиллагааны хэвийн жигд байдал хангагдсан	100	100	Архангай аймагт Хангайн бүсийн "Сувилахуйн сургалт, эрдэм шинжилгээ, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний цогцолбор" шинээр байгуулагдан үйл ажиллагаагаа явуулж байна. Уг цогцолборын Сувилахуйн сургуульд суралцаж буй 102 оюутанд аймгийн Засаг даргын нэрэмжит сургалтын төлбөрийн 50 хувийн тэтгэлэг болох 162.5 сая төгрөгийг олголоо. Тус сургууль цаашид тогтвортой үйл ажиллагаа явуулснаар Хангайн бүсийн эрүүл мэндийн салбар дахь сувилалч, тусгай мэргэжилтний боловсон хүчний нөөц 2028 он гэхэд бүрэн хангагдах юм. Эрүүл мэндийн салбарын шилдгээр нийт 70 эмч, эмнэлгийн мэргэжилтэн, 2 шилдэг менежменттэй байгууллагыг шалгаруулж, аймгийн орон нутгийн төсвөөс 197.8 сая төгрөгийн урамшуулал олгож, салбарын хүний нөөц, байгууллагын чадавхыг дэмжиж ажиллалаа. Аймгийн эрүүл мэндийн салбарын шилдгүүдийг эмч, сувилгачаас гадна багийн эмч, нийгмийн эрүүл мэндийн ажилтан, эмнэлгийн тусгай мэргэжилтэн гэсэн 5 төрөлд шалгаруулсан нь салбарын бүх шатны мэргэжилтнүүдийн үнэлэмж, оролцоо, хамрах хүрээг нэмэгдүүлсэн арга хэмжээ боллоо. "Эрүүл шүд-Архангай" арга хэмжээг 2023 оноос хэрэгжүүлэн ажиллаж байгаа бөгөөд 2024 онд орон нутгийн төсвөөс 296.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 6 сумын Эрүүл мэндийн төвийг шүдний кабинеттэй болгож, 2025 онд төсөл, хөтөлбөрийн дэмжлэгээр нэмэлтээр 3 суманд шинээр байгууллаа. Ийнхүү нийт 17 сумын Эрүүл мэндийн төв хөдөөгийн хүн амд шүдний эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлэх боломжтой болж, шүдний өвчлөлийг бууруулах хүний нөөц, тоног төхөөрөмжийн хүртээмж сайжирч байна. 2026 онд ерөнхий боловсролын сургуулиудад "Шүд угаах цэг" байгуулж, хүүхдүүдэд зөв дадал хэвшүүлэх ажлыг АШУГИС-тай хамтран шат дараатайгаар хэрэгжүүлэхээр төлөвлөж байна. Аймгийн хүн амын эрүүл мэндийн эрсдэлийг бууруулах зорилгоор 0-17 насны хүүхдийн эрт илрүүлийг сум, ерхийн Эрүүл мэндийн төвд, 18-ас дээш насны хүн амын эрт илрүүлийг аймгийн Нагдсан эмнэлгийн Эрүүл мэндийг дэмжих төв, 3 хувийн хэвшлийн эмнэлэгт тус тус зохион байгуулж байна. Ингэснээр аймгийн хэмжээнд 49,764 иргэн буюу нийт хүн амын 53.1 хувийг эрт илрүүлтэй хамруулан хүн амын өвчлөлийн эрсдэлийг бууруулж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний үр нөлөөг сайжруулан ажиллаж байна.	Архангай
12	71701	Биеийн тамир спорт	1,368,939.9	906,223.8	66.20%	Соёл, урлаг, биеийн тамир, спортын байгууллагуудын үйл ажиллагааны хэвийн жигд байдал хангагдсан	хувь	2024	Соёл, урлаг, биеийн тамир, спортын байгууллагуудын үйл ажиллагааны хэвийн жигд байдал хангагдсан	100	100	Биеийн тамир спортын газарт улсын төсвөөс 1,496,716,500.00 төгрөг, орон нутгийн төсвөөс 1,368,939,900 төгрөг нийт урсгал зардалд төсвөөс 2,865,656,400.00 төгрөгийн санхүүжилт авсан. ЗДНХ 113,230,000.00 төгрөг, ДШТЗ 317,552,900.00 төгрөг, Үндсэн үйл ажиллагааны орлого 58,592,800.00 төгрөгийн санхүүжилт Үүнээс Байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 790,580,727.78 төгрөг, Эд хогшил, урсгал засварын зардалд 142,906,540.00 төгрөг, Цалин хөлс нийгмийн даатгалд 1,327,764,467.30 төгрөг, Хангамж, бараа материалын зардалд 27,278,280.00 төгрөг, Томилголт, зочны зардалд 780,000.00 төгрөг, Бараа үйлчилгээний зардалд 270,465,000.00 төгрөг, Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамж 3,596,800.00 төгрөг, Идэвхтэй амьдралын хэвшлийг дэмжих 29,551,338.00 төгрөг, Үндэсний тэмцээн, наадамьн үйл ажиллагаа 61,411,580.00 төгрөг, Биеийн тамирын уралдаан, тэмцээн 69,540,000 төгрөг, Нийтийн биеийн тамир 44,337,400 төгрөг, Ажил олгогчос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг 1,500,000.00 төгрөгийг одоогийн байдлаар зарцуулсан байна. Төсвийг зарцуулахдаа холбогдох хууль тогтоомжийн дагуу захиран зарцууллаа.	Архангай
13	71702	Соёл урлаг	1,774,887.3	1,221,849.3	68.84%	Соёл урлаг				100	100	Соёл урлаг, аялал жуулчлал, залуучуудын газар 1, Хөгжимт драмын театр 1, Музей 1, Нийтийн болон хүүхдийн номын сан 1, соёлын төв 18 үйл ажиллагаа явуулж тэдгээрт нийт 239 албан хаагч ажиллаж байна. 2025 онд 18 соёлын төвд 1,463 арга хэмжээ зохион байгуулагдаж тэдгээрт давхардсан тоогоор 301.5 мянган иргэн хамрагдсан байна. 18 сумын соёлын төвүүдийн орон нутгийн байр ашиглалттай холбоотой гарах тогтмол зардлын санхүүжилт 100 хувь олгогдож өр авлаггүй ажиллаж байна. Соёл урлагийн 22 байгууллагын тогтмол зардалд 2024 онд орон нутгийн төсвөөс 2.2 тэрбум төгрөгийг зарцуулан, үйл ажиллагааг хэвийн явуулж байна. Орон нутгийн төсвийн 414.1 сая төгрөгийн санхүүжилтээр 1 сумын Соёлын төв болон хүүхдийн номын сангийн засварын ажлыг гүйцэтгэсэн.	Архангай
14	71801	Сургуулийн өмнөх боловсрол	2,557,676.4	2,331,572.9	91.16%	СӨБ-ын хамран сургалтын цэвэр жин	хувь	2024	89.2	89.4	90.1	Аймгийн хэмжээнд СӨБ-ын 35 байгууллага үйл ажиллагаагаа хэвийн явуулж байна. 2025-2026 оны хичээлийн жилд аймгийн хэмжээнд 2-5 настай нийт 7,220 хүүхдээс сургуулийн өмнөх боловсролд 6,662 хүүхдийг хамруулж, хамран сургалт 90.2%, аймгийн хэмжээнд 5 настай 1,882 хүүхэд байгаагаас 1,779 нь 35 цэцэрлэгт, 103 нь өөр аймаг хотод сургуулийн өмнөх боловсрол эзэмшиж байна. Хөгжлийн бэрхшээлтэй нийт 55 хүүхдээс 46 хүүхэд нь сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамрагдаж байна. Үүнээс үндсэн бүлэгт 35, явуулын багшийн сургалтад 12, цаашид хувилбарт сургалтад хамрагдах 9 хүүхэд байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтын хувь 83.6 хувьтай байна. Нийт 35 цэцэрлэгийн 5 настай 1782 хүүхэд сургуульд бэлтгэгдсэн байдлын үнэлгээнд хамрагдан 71.25%-тай дүгнэгдэж улсын дунджаас 1.77%-р дээгүүр үнэлэгдлээ. Сургуулийн өмнөх боловсролд хамрагдаж буй хүүхдүүдийн дугуйлан өсөхөд хамрагдалт, урлагийн төрөлд-7851, спортын төрөлд-984, дүрслэх урлаг, сэтгэх чадварын төрөлд-1,551, бусад төрлөөр-783 нийт 11,169 хүүхдийн авьяас чадварыг хөгжүүлэх үйл ажиллагаанд хамруулсан байна. Хичээлийн жилийн төгсгөлд зохион байгуулсан "Архангай-Ирээдүйн эзэд" тайлант өдөрлөгийн арга хэмжээнд цэцэрлэгийн 470 хүүхэд оролцож, урлаг спортын үзүүлбэр үзүүллээ. Монголын болон аймгийн Мастер тогоочдын холбоотой хамтран хүүхдийн цэцэрлэгийн нийт 55 тогоочийг орчин үеийн дэвшилтэт технологиор эрүүл, илчлэг шим тэжээлтэй, шинэлэг хоол ундааны төрлүүдийг хийж сургах, хүүхдийн хоолны шим тэжээлийг сайжруулах, хоол үйлдвэрлэлд эрүүл ахуйн болон үйлдвэрлэлийн зохицтой дадлыг мөрдөж хэвших зэрэг үр чадварыг дээшлүүлээ. Аймаг сумдын цэцэрлэгүүдийн орон нутгийн байр ашиглалттай холбоотой гарах тогтмол зардлын санхүүжилт 100 хувь олгогдож өр авлаггүй ажиллаж байна. Орон нутгийн төсвийн 826.5 сая төгрөгийн санхүүжилтээр Эрдэнэбулган сумын 1, 11 дүгээр цэцэрлэгүүдийн барилгыг засварлаж багш, сурагчдын ажиллаж сурч хөгжих таатай орчин бүрдүүлээ.	Архангай

№	Хөтөл-бөрийн код	Хөтөлбөрийн нэр	Батлагдсан төсөв	Төсвийн гүйцэтгэл	Төсвийн гүйцэтгэлийн %	Хөтөлбөрийн үр дүнгийн шалгуур үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Суурь он	Суурь түвшин	2025 оны зорилтот түвшин	Хүрсэн түвшин	Тайлбар	Аймаг
15	71802	Ерөнхий боловсрол	6,320,131.3	6,074,770.9	96.12%	Суурь боловсролын хамран сургалтын цэвэр жин	хувь	2024	90.8	91	90.1	2025-2026 оны хичээлийн жилд аймгийн ерөнхий боловсролын 30 сургуулийн 697 бүлэгт 19,823 сурагч /үүнээс эмэгтэй 9,818 /өдрийн ангид суралцаж, орой, эчнээгээр суралцагч байхгүй, дүйцсэн хөтөлбөрөөр 162 /эм-27/, нийтдээ эдгээр сургалтын хэлбэрээр 19,985 хүүхэд /үүнээс эмэгтэй 9,845/ суралцаж байна. Суурь боловсролын хамран сургалт 93.2 хувь, бага боловсролын хамран сургалт 93.9 хувь, 6 настай хүүхдийн сургуульд хамрагдалтын хувь 89.3 хувь байна. Нийт суралцагчдын 10268 /үүнээс эм-5033/ нь малчдын хүүхэд байна. Аймаг сумдын ЕБС-ийн орон нутгийн байр ашиглагдтай холбоотой гарах тогтмол зардлын санхүүжилт 100 хувь олгогдож өр авлагагүй ажиллаж байна. Орон нутгийн төсвийн 2,505.7 сая төгрөгийн санхүүжилтээр Хөшөөт, Өлзийт, Цэцэрлэг, Өндөр-Улаан, Эрдэнэмандал, Хотонт, Эрдэнэбулган сумын 5 дугаар сургуулийн хичээлийн байр, дотуур байр, спорт заалыг засварлан багш суралцагчдын ажиллах суралцах таатай орчинг бүрдүүлжээ. ЕБ-ын 30 сургуульд хүүхдийн авьяас чадварыг хөгжүүлэх 402 дуулиан, сөх /33 төрөл-г хичээллүүлж 15,043 хүүхэд хамруулсан нь нийт суралцагчдын 75.7%-ийг эзэлж байна. Дуугуйланд хамрагдсан сурагчдаас "Ганга мөрийн уянга", "Ая эгшин зургаан жигүүр", "Оломгүй далай", "Уран жиргээ", "Шувуухай", "Би эсдрдын дуучин", "Найрал дуу"- ны Улсын уралдаанд 75 сурагч оролцон 1,2,3 дугаар байр эзэлжээ. Мөн хүүхдийн хөгжил, оролцоог дэмжих Хичээлээс гадуурх байгаль экологийн 53 төрлийн ажилд-3940, соёл урлагийн 53 үйл ажиллагаанд 12,048 сайн дурын 31 үйл ажиллагаанд-2,474, Эх оронч үзэл төлөвшүүлэх 25 үйл ажиллагаанд-1725, СӨУЗ 68 төрлийн үйл ажиллагаанд-1,394 сурагчийн хамруулсан. Эрдэнэбулган сумын 1, 2, 3 дугаар сургууль дээр Энхтайваны корпусын сайн дурын ажилтнуудтай хамтарсан "Сэтгэл зүйч", "Ном уншигч", "Сэтгүүлч", "Амьдрах чадвар", "Game club", "Гар урлаг", "Гар урлаг" бичиг клуб ажиллаж байна. Клубийн 100 гаруй сурагч хандлага, ёс зүй, олон нийтийн харилцааны чиглэлээр нөлөөллийн болон чадваржуулах үйл ажиллагааг багш, сурагч, олон нийтэд явуулж байна. Хичээлийн жилийн төгсгөлд зохион байгуулсан "Архангай-Ирээдүйн эзэд" тайлант өдөрлөгийн арга хэмжээнд ЕБС-ийн 524 сурагч оролцож, урлаг спортын үзүүлбэр үзүүлжээ.	Архангай
16	71804	Мэргэжлийн боловсрол	261,699.1	200,775.2	76.72%	Нийт төгсөгчдөд мэргэжлээрээ ажиллаж байгаа төгсөгчдийн эзлэх хувь	хувь	2024	58.8	61.2	65.0	2025-2026 оны хичээлийн жилд аймгийн 2 политехникийн коллеж, 1 мэргэжлийн боловсролын сургуульд нийт 1.608 оюутан суралцаж байна. Өмнөх хичээлийн жилээс 171 оюутан нэмэгдсэн байна. 2024-2025 оны хичээлийн жилд аймгийн 2 политехникийн коллеж, 1 мэргэжлийн боловсролын сургуульд нийт 1.437 оюутан суралцсанаас 790 суралцагчийг 82 аж ахуйн нэгжид дадлагад хамруулж ур чадвар эзэмшүүлжээ. 2025 онд Архангай ПТК төгсөгчдийн 80%, Гурвантамир ПТК төгсөгчдөөс 85%, Булган МБС төгсөгчдийн 75.3%, нь ажлын байртай болсон байна.	Архангай
17	71902	Нийгмийн халамж	136,105.8	87,888.3	64.57%	Халамжийн сангийн хүртээмж	хувь	2024	100	100	100.0	Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээг үзүүлэхээр "Бид танд туслая", "Сэтгэлийн сэвшээ" ТББ-тай гэрээ байгуулан ажиллаа. Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2025 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн А/53, А/35 тоот тушаал болон холбогдох хууль журмыг танилцуулан 5 удаа мэргэжил арга зүйгээр хангах нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрх, иргэнийг нийгэмшүүлэх, хамт олны бүлэг бүрдүүлэх, орлогын аж үзвэртэй болгох төсөл хэрэгжүүлэх, амьдрах ухаанд сургах үйлчилгээнд 50 өрх, 185 иргэнийг хамруулав. Аймаг, сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлын дэргэдэх, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөл, Хүүхэд гэр бүлийн хөгжил, хамгааллын газраас 3 суманд "эрсдэлгүй ирээдүй" аяныг зохион байгуулж 14 иргэнийг хамруулан 2 иргэнд ганцаарчилсан сэтгэл зүйн зөвлөгөө, 8 иргэнд урьдчилан сэргийлэх эрт илрүүлийн шинжилгээ хийж, 6 иргэнд мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтад хамруулан түр ажлын байранд 3 иргэнийг зуучилсан.	Архангай
18	72101	Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих	3,864,060.1	1,543,959.9	39.96%	Зээл авсан хоршоо	тоо	2024	74	75	27.0	Засгийн газрын 2020 оны 113 дугаар тогтоолоор батлагдсан Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, дамжуулан зээлдүүлэх, эргэн төлүүлэх, хяналт тавих журмын хүрээнд 2025 онд жижиг дунд үйлдвэр хөгжүүлэх сангаас 3 аж ахуй нэгжид 446.9 сая төгрөгийн зээл олгож 15 ажлын байр бий болсон байна. "Шинэ хоршоо" хөдөлгөөний хүрээнд 615 хоршооны 2,272 малчинд 65.4 тэрбум төгрөгийн зээл олгоосон байна. "Хоршоо хөгжүүлэх сан"-аас хүнс үйлдвэрлэл, хөнгөн үйлдвэрлэл, газар тариалан, мал аж ахуй, барилга, худалдаа үйлчилгээ, бусад чиглэлээр 11 сум 27 хоршоонд 1.6 тэрбум төгрөгийг олгож 80 ажлын байр бий болсон байна.	Архангай
19	72208	Ахмад настны хөгжил хамгаалал	82,937.2	82,937.2	100.00%	Аймгийн ахмадын хорооны үйл ажиллагааг хэвийн жигд байдал	хувь	2024	Аймгийн ахмадын хорооны үйл ажиллагааг хэвийн жигд байдал хангагдсан	100	100.0	Цэцэрлэг сумын ахмадын хороо "Ахмадуудын оролцоо-2025" аж ахуйн нэгж, хүүхэд залуучуудын дунд гар бөмбөгийн тэмцээн, Ихтамир сум "Ахмад мэргэжилтний нэг өдөр" арга хэмжээг зохион байгуулах зэргээр сум бүр өмнөх хэрэгцээндээ тулгуурлан уулзалт, хэлэлцүүлгийн тогтмол хийж хэвшээд байна. Ихэнхдээ сургууль, цэцэрлэгүүд ахмад багш нарын туршлагаг залуу үедээ зааж сургах ажлыг илүү үр дүнтэй зохион байгуулж байна. Аймгийн хэмжээнд "Ардын сайхан хангайн ахмадууд - бид үе тэнгийнхэн" урлаг, спортын бүсийн тэмцээн гэх мэт 27 арга хэмжээ зохион байгуулж 400 гаруй ахмад, 627 залуучуудтай хамтран ажилласан байна. Аймгийн эрүүл мэндийн газар, өрхийн эрүүл мэндийн төвүүд, сумын Засаг дарга, нийгмийн ажилтнуудтай хамтран цогц үнэлгээ хийх талаар сургалт мэдээллийг Төвшүүрлэх, Ихтамир, Эрдэнэбулган сумдад зохион байгуулж 260 ахмад настанд үнэлгээ хийлээ. Үнэлгээнд хамрагдсан ахмадын 70 хувь нь 1 болон 2-р түвшинд үнэлэгдсэн байна. Олон улсын ахмадын баярыг тохиолдуулан орон нутгийн мэргэжлийн хамтарсан багийн салбар байгууллагууд хамтран аймгийн 19 сумын ахмад настануудыг хамруулан урлаг, спортын наадам, эрүүл мэндийн сорил, урьдчилан сэргийлэх үзлэг зэргийг зохион байгуулаа эрүүл мэндийн сорилд 52 ахмад настан хамрагдсанаас 50 ахмад настан С буюу өхөлгөлттэй, биеийн жин ихтэй, 2 ахмад настан Д буюу биеийн жин хэвийн оношлогдсон байна.	Архангай
20	70411	Төрийн архив, албан хэрэг хөтлөлт	86,622.1	78,472	90.59%	Архивын хэлтсийн үйл ажиллагааг хэвийн жигд байдал	хувь	2024	Архивын хэлтсийн үйл ажиллагааг хэвийн жигд байдал хангагдсан	100	100.0	Төрийн архивын сан хөмрөгт хадгалагдаж байгаа 36 хөмрөгийн 486 хадгаламжийн нэгж, 97,086 хуудас баримтыг их бүрэн цахим санд шилжүүлж, ингэснээр иргэдэд чирэгдэлгүй, хөнгөн шуурхай үйлчлэх нөхцөл бүрдүүлж ажиллалаа. 1,140 иргэн, давхардсан тоогоор 57 байгууллага, 3 судлаачийн хүсэлт захиалга, 3 иргэний өргөдөлийг хүлээн авч шийдвэрлэн ажилласан. Давхардсан тоогоор 140 байгууллагын 436 албан хаагчид хадгаламжийн нэгж бүрдүүлэх, данс бүртгэл үйлдэх, албан бичиг боловсруулах, хуралдааны тэмдэглэл хөтлөх талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан. 2 дугаар сарын 14, 15-ны өдрүүдэд "Архивчдын хөгжил, сургалт арга зүйн төв" ТББ, Хэлний бодлогын салбар зөвлөл дэх Монгол хэл бичгийн багш нартай хамтран архив, бичиг хэргийн ажилтнуудыг чадавхжуулах нэгдсэн сургалт зохион байгуулж, сургалтад 183 байгууллагын 185 албан хаагчийг хамруулсан. Архив, албан хэрэг хөтлөлийн улсын үзлэгт багтүүлж эрэлтээр сум, байгууллагын архив, бичиг хэргийн ажилтнуудад 2 удаагийн очилтын сургалт зохион байгуулж 230 албан хаагчийг хамруулсан. Мөн 12 дугаар сарын 05-ны өдөр Архив, бичиг хэргийн ажилтнуудыг чадавхжуулах сургалтыг "Насан туршийн суралцахуйн төв", Монгол хэл бичгийн багш нартай хамтран зохион байгуулж тус сургалтад 121 албан хаагчийг хамруулсан. Төрийн архив, албан хэрэг хөтлөлт, байгууллагын ажлын зохион байгуулалтын улсын үзлэгт орон нутагт зохион байгуулж ажилласан. Үзлэгт төрийн байгууллагууд болон төрийн өмчит аж ахуйн нэгж нийт 165 байгууллагын архив, албан хэрэг хөтлөлийн үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийж зөвлөмж, дүгнэлт өгч ажиллалаа.	Архангай

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ

№	Хөтөл-бөрийн код	Хөтөлбөрийн нэр	Батлагдсан төсөв	Төсвийн гүйцэтгэл	Төсвийн гүйцэтгэлийн %	Хөтөлбөрийн үр дүнгийн шалгуур үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Суурь он	Суурь түвшин	2025 оны зорилтот түвшин	Хүрсэн түвшин	Тайлбар	Аймаг
1	70106	Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын үйл ажиллагаа	36,213,057.70	32,228,928.00	89.0%	Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилт, хөтөлбөрүүд түүний хэрэгжилтийг ханган ажилласан байдал	хувь	2024	95	95	91.5	Аймгийн ИТХ-ын 30 дугаар тогтоолоор Төсвийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.6.4-д заасныг үндэслэж аймгийн Төсвийн ерөнхийлөн захиралчийн 2025 онд хэрэгжүүлэх 21 хөтөлбөрийн хүрэх үр дүн, чанарын болон тоон үзүүлэлтийг 19 шалгуур үзүүлэлтээр баталсан байна. Аймгийн ИТХ-ын 2025 оны 58 дугаар тогтоолоор 2025 онд хэрэгжүүлэх 21 хөтөлбөрийн хүрэх үр дүн, чанарын болон тоон үзүүлэлтийг 19 шалгуур үзүүлэлтээр баталж хэрэгжилтийг ханган ажилласан болно.	Баян-Өлгий
						Төрийн байгууллагын чадавхыг бэхжүүлж, харилцаатай, ёс зүйтэй, мэргэшсэн, тогтвортой, шударга төрийн албыг бий болгох замаар үйл ажиллагааны хэвийн жигд байдлыг хангасан эсэх	хувь	2024	100	100	100	ТЭЗ-ийн харьяа төсөвт байгууллагын чадавхыг бэхжүүлж, харилцаатай, ёс зүйтэй, мэргэшсэн, тогтвортой, шударга төрийн албыг бий болгох замаар үйл ажиллагааны хэвийн жигд байдлыг ханган ажилласны дүнд хөтөлбөрийн хэрэгжилт 100 хувь байна.	Баян-Өлгий
			2,459,570.10	1,556,160.70	63.3%	Засаг захиргааны байгууллагын анхан шатны нэгж, түүний үйл ажиллагааны хэрэгжилт	Хувь	2024	90	95	93	Тайлант онд Засаг захиргааны анхан шатны нэгж болох 99 багийн үйл ажиллагаа явуулсан ба хөтөлбөрийн хэрэгжилт 93 хувьтай гэж дүгнэгдсэн.	Баян-Өлгий
						Засаг даргын нөөц хөрөнгө зориулалтын дагуу зарцуулагдсан эсэх	хувь	2024	100	100	96	Засаг даргын нөөц хөрөнгө 2,459.6 мянган төгрөгөөр төлөвлөснөөс гүйцэтгэлээр 1,556.2 мянган төгрөг зарцуулсан, гүйцэтгэлийн хувь 63.3 хувь байна. Нөөц хөрөнгийн зарцуулалтын 45 хувийг нэг удаагийн буцаалтгүй тусламж, эмчилгээний зардалд, 13 хувийг арга хэмжээ, хүлээн авалтын үйл ажиллагаанд, 42 хувийг нэгжийн осол, байгалийн эрсдэл болон бусад арга хэмжээнд зарцуулсан байна.	Баян-Өлгий
2	70105	Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын үйл ажиллагаа	3,738,307.10	3,064,843.10	82.0%	Хуралдааны шийдвэр	тоо	2024	11	13	13.0	Аймгийн ИТХ-ын орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын үйл ажиллагаа хөтөлбөрийн хүрэх үр дүнг 2 шалгуур үзүүлэлтээр дүгнэсэн ба зорилтот түвшний биелэлт 101.7 хувьтай, төсвийн гүйцэтгэл 82 хувьтай байна.	Баян-Өлгий
						Өргөдөл гомдол, саналын шийдвэрлэлтийн байдал	тоо	2024	58	60	62.0		Баян-Өлгий
3	70709	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлийн үйл ажиллагаа	508,816.40	258,134.50	50.7%	Гэмт хэргийн бууралт	Хувь	2024	10	10	10	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хөтөлбөрийн хүрэх үр дүнг 1 шалгуур үзүүлэлтээр дүгнэхэд, зорилтот түвшний биелэлт 100.0 хувийн гүйцэтгэлтэй, төсвийн зарцуулалт 50.7 хувь байна.	Баян-Өлгий
4	70411	Төрийн архив, албан хэрэг хөтөлөлт	275,846.00	275,828.10	100.0%	Стандартын дагуу бүрдүүлсэн хадгаламжийн нэгжийн тоо /мянгаар/	тоо	2024	10200	10350	10300	Аймгийн Архивын хэлтэс нь тайлант онд батлагдсан төсөвөө 100 хувь зарцуулсан ба хөтөлбөрийн хэрэгжилт мөн 100 хувь байна.	Баян-Өлгий
5	70429	Мэргэжлийн хяналт	357,085.50	333,557.30	93.4%	Илэрсэн зөрчлийн бууралт	хувь	2024	100	100	98	Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны тайлант оны батлагдсан төсвийн гүйцэтгэл 93.4 хувь хөтөлбөрийн хэрэгжилт 98 хувьтай байна.	Баян-Өлгий
6	70426	Төрийн өмчийн эрхийг хэрэгжүүлэх	501,420.90	483,697.20	96.5%	Үйл ажиллагааны хэрэгжилт	хувь	2024	100	100	100	Орон нутгийн өмчийн харилцааны оновчтой бодлого, холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлэн, хөрөнгийн ашиглалт, хамгаалалт, бүртгэлээр тавих хяналтыг хэрэгжүүлэх ажлын хэрэгжилт 100 хувьтай ба төсвийн гүйцэтгэл 96.5 хувь байна.	Баян-Өлгий
7	70425	Орон нутгийн хөвчлэл, мэдээллийн үйл ажиллагаа	825,266.50	606,313.70	73.5%	Үйл ажиллагааны хэрэгжилт	хувь	2024	100	100	100	Иргэд олон нийтийг өдөр тутмын мэдээ мэдээллээр хангах, төр засгийн бодлого, шийдвэрийг сурталчлан таниулах, орон нутгийн цаг үеийн асуудлыг ард иргэдэд шуурхай хүргэх хөвчлэл мэдээллийн үйл ажиллагааны хэрэгжилт 100 хувь, байгууллагын төсвийн гүйцэтгэлийн хувь 73.5 байна.	Баян-Өлгий
8	71413	Хүрээлэн буй орчны бодлого, удирдлага	1,418,927.20	1,290,496.40	90.9%	хашиж хамгаалсан булаг шанд, рашаан	тоо	2024	10	10	10	Тайлант онд хашиж хамгаалах булаг шанд, рашааны тоо 10 байхаас гүйцэтгэл 10 болж үйл ажиллагааны хэрэгжилт 100 хувь байна.	Баян-Өлгий
						Аялагчдын тоог нэмэгдүүлэх	тоо	2024	65000	66000	68000	Аялагчдын тоо суурь оноос 3,000 мянган хүнээр нэмэгдсэн дүэтэй байна.	Баян-Өлгий
9	71403	Ойжуулалт	352,147.80	316,398.60	89.8%	Шинээр тарьсан суулгацын хэмжээ	тоо	2024	84000	85000	85000	Ойн нөөц, биологийн төрөл зүйлийг хамгаалах, нөхөн сэргээх, ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлэх арга хэмжээ авах, аймгийн хот, суурин газрыг тогтвортой хөгжүүлж, хотын иргэдийн одоогийн ба ирээдүйн эрүүл, аюулгүй байдлыг хангах, амьдрах таатай орчныг бүрдүүлсэн, өрсөлдөх чадвартай хот суурин газрыг бий болгох зорилгоор аймагт үйл ажиллагаа явуулдаг сум дундын ойн анги нь тайлант онд 85,000 ширхэг суулгац тарьж ургуулсан байгаа нь суурь оноос 1,000 суулгацаар илүү байна. төсвийн гүйцэтгэл 78.8 хувьтай байна.	Баян-Өлгий
10	71502	Хот байгуулалт, тохижилт	1,425,587.80	1,413,214.00	99.1%	хэрэгжүүлсэн, төсөл арга хэмжээнүүдийн биелэлт	хувь	2024	98	100	100	Аймгийн хот тохижуулах байгууллагын тайлант оны төсвийн гүйцэтгэл 99.1 хувьтай, үйл ажиллагааны хэрэгжилт 100 хувьтай гэж дүгнэгдсэн. Тайлант онд аймгийн төвийн тохижилт, гэрэлтүүлэг зэрэгт нийт 4 төсөл арга хэмжээ төлөвлөн хэрэгжүүлж ажилласан байна.	Баян-Өлгий
11	71902	Нийгмийн халамж	472,002.70	436,688.10	92.5%	Мэргэжил эзэмшиж, ажлын байртай болсон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоо өссөн байна	тоо	2024	11	12	12	12 хөгжлийн бэрхшээлтэй иргэнд мэргэжил олгож, ажлын байраар ханган ажилласан байна.	Баян-Өлгий
						Зорилтот бүлгийн өрхийн амьжиргааны түвшин дээшилсэн байна	тоо	2024	50	50	50	Зорилтот бүлгийн өрхийн амьжиргааны түвшин дээшилсэн 50 иргэн байна.	Баян-Өлгий
						Асруулагчийн ая тухай орчинг бүрдүүлж, амьдралын тогтвортой байдлыг хангасан байдал	тоо	2024	14	14	14	Аймгийн асрамжийн газарт 14 асруулагч аж төрж амьдарч байна.	Баян-Өлгий
12	71101	Автозам	1,311,400.00	975,216.10	74.4%	Замын сангаас хэрэгжүүлсэн 46 нэр төрлийн замын ажлын биелэлт	хувь	2024	100	100	85	Замын сангаас 46 нэр төрлийн замын ажлын төсөл арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөсөн боловч 3 төсөл арга хэмжээг өт хэрэгжээгүй 43 төсөл арга хэмжээ бүрэн хэрэгжсэн. ба төсвийн гүйцэтгэл 74.4 хувьтай, зарим нэгэн төсөл арга хэмжээний санхүүжилтийг 2026 онд он дамжуулан олгосон тул төсвийн гүйцэтгэл бага гарахад нөлөөлсөн байна.	Баян-Өлгий
13	70106	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага, үйл ажиллагаа	2,152,168.10	1,990,761.80	92.5%	Ахмадын хорооны үйл ажиллагааг дэмжин ажиллах	сая.төг	2024	93	93	93	Тайлант онд аймгийн ахмадын хорооны үйл ажиллагааг дэмжих зорилгоор Засаг даргын өрөнхий данснаас санхүүжилт олгосон.	Баян-Өлгий
						Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласан байдал	хувь	2024	100	100	100	Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор Засаг даргын өрөнхий данснаас эм бэлдмэл, эмнэлгийн хэргэсэл худалдан авахад зориулж 175.9 сая төгрөг, малын эмч нарын үйлчилгээний хөлсөнд 276.7 сая төгрөг тус тус төлөвлөн санхүүжүүлсэн байна.	Баян-Өлгий
						Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	хувь	2024	100	100	98	Аймгийн төрийн үйлчилгээний нэгдсэн төвийн барилгын тогтмол зардалд мөн Засаг даргын өрөнхий данснаас тайлант онд 213.0 сая төгрөгийг санхүүжүүлсэн байна.	Баян-Өлгий
						Орон нутагт байгаа улсын төсвийн байгууллагуудад олгох орон нутгийн нэмэгдэл	хувь	2024	100	100	90	Орон нутагт үйл ажиллагаа явуулдаг улсын төсвийн байгууллагуудын төрийн албан хаагчдад орон нутагсаа олгох орон нутгийн нэмэгдэл болох 1121.4 сая төгрөгийг Засаг даргын өрөнхий дансаар дамжуулан олгосон.	Баян-Өлгий

№	Хөтөл-Бөрийн код	Хөтөлбөрийн нэр	Батлагдсан төсөв	Төсвийн гүйцэтгэл	Төсвийн гүйцэтгэлийн %	Хөтөлбөрийн үр дүнгийн шалгуур үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Суурь он	Суурь түвшин	2025 оны зорилтот түвшин	Хүрсэн түвшин	Тайлбар	Аймаг
14	70503	Зорилтот хөрөнгө оруулалт	7,151,100.00	5,926,000.00	82.9%	Орон нутгийн хөрөнгө оруулалтыг хуулийн дагуу зохицой төлөвлөн, хэрэгжүүлсэн байдал	тоо	2024	37	37	34	Аймгийн Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөө 7,151.1 сая төгрөг, гүйцэтгэл 5,926.0 сая төгрөг байна. Орон нутгийн хөрөнгө оруулалтаар боловсрол, эрүүл мэнд, соёлын салбаруудын их засварын ажилд 5,099.1 сая төгрөгийн, бусад хөрөнгө оруулалтын ажилд 2,052.0 сая төгрөгийн нийт 7,151.1 сая төгрөг төлөвлөсөн ба орон нутгийн орлогын бүрдэлтээ шалтгаалж санхүүжилтийн 82.9 хувь буюу 5,926.0 сая төгрөгийн санхүүжилт олгоосон байна. Боловсрол, эрүүл мэнд, соёлын салбарын их засварын хөрөнгө оруулалтын ажлуудаас дутуу хэрэгжсэн төсөл арга хэмжээ байхгүй байна. Өмнөх оноос шилжиж ирсэн 7 төсөл арга хэмжээ, 2025 онд шинээр хэрэгжүүлэх 33 төсөл арга хэмжээ, нийт 4,837.4 сая төгрөгийн их засварын ажил хийгдсэн байна.	Баян-Өлгий
15	70503	Зорилтот хөрөнгө оруулалт	12,333,703.70	9,994,997.00	81.0%	ОНХсангийн хэрэгжилтийн хувь	хувь	2024	100	100	90	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох орлогын шилжүүлгийн төлөвлөгөө 9,395.6 сая төгрөг ба гүйцэтгэлээр 9,310.6 сая төгрөгийн санхүүжилт хүлээн авсан. Үүнээс 3,410.7 сая төгрөгийг аймгийн Орон нутгийн хөгжлийн санд, 5,899.9 сая төгрөгийг сумуудын Орон нутгийн хөгжлийн санд хуваарилсан байна. Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөгөө 3,493.9 сая төгрөг, гүйцэтгэл 3,410.7 сая төгрөг оны эцэст зарцуулагдаагүй үлдэгдэл 83.2 сая төгрөг байна. Сумуудын Орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөгөө 5,901.7 сая төгрөг, гүйцэтгэл 5,899.9 сая төгрөг ба дараа онд шилжих үлдэгдэл 1.8 сая төгрөг байна.	Баян-Өлгий
16		Орон нутгийн төсөвт байгууллагуудын хэвийн үйл ажиллагааг хангах	6,888,087.30	6,728,247.70	97.7%	Орон нутгийн төсөвт байгууллагын тогтмол зардлын санхүүжилтийг бүрэн олгож, хэвийн үйл ажиллагааг хангагдсан байдал	хувь	2024	100	100	100	Орон нутгийн төсөвт байгууллагуудын хэвийн үйл ажиллагааг хангах ажиллагааны төсвийн гүйцэтгэл 97.7 хувьтай байна.	Баян-Өлгий
17	70418	Худалдан авах ажиллагаа	384,812.30	374,506.90	97.3%	Үйл ажиллагааны хэрэгжилт	хувь	2024	100	100	100	Төрийн худалдан авах ажиллагааг хууль тогтоомжийн хүрээнд ил тод, нээлттэй, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай зохион байгуулж, дүнж, тайлагнах гэж тодорхойлсон ба энэ хүрээнд зорилтын биелэлтийг бүрэн хангасан гэж тайлагнасан байгаа. Төсвийн гүйцэтгэл 97.3, хөтөлбөрийн хэрэгжилт 100 хувь байна.	Баян-Өлгий
<b>БАЯНХОНГОР АЙМАГ</b>													
1	70105	Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын үйл ажиллагаа	6,089,121.3	5,566,732.7	91.42%	Хурлын хуралдааныг улиралд 1-с доошгүй, удаа хуралдуулж шийдвэр гаргана.	тоо	2023	8	5	6	Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 35 төлөөлөгч, 20 сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 416 төлөөлөгчтэй үйл ажиллагаа явуулсан. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал нь 2025 онд 6 удаагийн хуралдаанаар 97 асуудал хэлэлцэж 85 тогтоол гаргасан бөгөөд 20 сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь 2025 онд 85 удаа хуралдсан байна. Сумын төсөв, сумын хөгжлийн төлөвлөгөө, биелэлт, газар зохион байгуулалт, үнэ, үнэ тариф тогтоох зэрэг асуудлыг холбогдох хууль тогтоомжид заасан бүрэн эрхийн хүрээнд хэлэлцсэн байна	Баянхонгор
2		Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх	574,836.0	519,630.3	90.40%	Аймгийн ГХУСА33-ийн ажлыг нэгдсэн төлөвлөгөөг баталж, гэмт хэргийн гаралтыг 5% бууруулна.	хувь	2023	577	548	706	Баянхонгор аймагт 2025 онд иргэн, хуулийн этгээдээс гэмт хэргэ, зөрчлийн шинжтэй 5045 дуудлага, мэдээлэл хүлээн авч шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 539 нэгжээр буюу 12 хувиар өссөн. Энэ хугацаанд 706 гэмт хэргэ бүртгэгдсэн нь өмнөх оноос 129 нэгжээр буюу 22.9 хувиар өсж, гэмт хэргийн илрүүлэлт 58.2 хувьтай байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 5.4 хувиар өссөн байна. Гэмт хэргэ өссөн шалтгаан нь Цахим залилан, хулгайлах, Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргэ, ХАБЭГХ голчилж байна. Мөн сумуудад ажиллаж буй 28 Олон нийтийн цагдааг тус арга хэмжээгээс цалинжуулж ажилласан байна.	Баянхонгор
3	70106	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	44,168,507.50	40,008,153.45	90.58%	Байгууллага агентлагуудыг бодлого, удирдлагаар хангаж ИТХ-ын тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хангах байгууллагын тоо,	тоо	2023	140	140	140	Баянхонгор аймгийн 2025 оны хөгжлийн төлөвлөгөөг Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын 2023 оны А/26 дугаар тушаалаар батлагдсан аргачлалаар боловсруулж аймгийн иргэдийн төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 4/27 дугаар тогтоолоор салбарын 20, төсвийн ерөнхийлөн захирагчийн 23, хөтөлбөрийн 34 үр дүнгийн хүрээнд 178 үндсэн үйл ажиллагаа, төсөл, арга хэмжээтэй батлан хэрэгжүүлсэн байна. Жилийн хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилт нь Аймгийн ИТХ-ын 2026 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн 11/13 дугаар тогтоолоор 89 хувьтай буюу "Үр дүн гарсан" дүнтэй үнэлэгдсэн байна	Баянхонгор
4			1,595,396.50	1,032,271.20	64.70%	Вакцинжуулах малын тоо /сая мал/	тоо	2023	0.85	1.90	1.9	Дархлаажуулалтад 1,938,300.0 сая толгой малыг хамруулж 1,595,396.5 сая төгрөг зарцуулахаар төлөвлөсөн бөгөөд 2025 оны жилийн эцсээр 13 нэр төрлийн халдвар өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад 1,937,300.0 толгой мал амьтныг хамруулж төлөвлөгөөг ажлыг 99.9 хувиар биелүүлсэн.	Баянхонгор
5	71101	Авто зам	2,035,484.0	2,031,705.5	99.81%	Хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний тоо	тоо	2023	15	15	15	Замын сангийн хөрөнгө оруулалтаар 2025 онд 15 төсөл, арга хэмжээг 2,031,705.5 мянган төгрөгөөр хэрэгжүүлж ажилласан байна. Баянхонгор сумын 3-р сургуулийн баруун урд уулзвараас Арван мянгатын бетон зам хүртэлх 1 км авто зам тавих ажлыг бүрэн дуусгаж бусад нийтийн эзэмшлийн зам талбайн цэвэрлэгээ арилгаа тохижилтыг сайжруулсан байна.	Баянхонгор
6	71502	Хот байгуулалт тохижилт	2,685,172.2	2,619,172.6	97.54%	Цэвэрлэгээ хийсэн зам талбайн хэмжээ, нэмэгдүүлсэн ногоон байгууламжийн хэмжээгээр	М2	2023	365	365	369	Баянхонгор сумын нийтийн эзэмшлийн 368,890 м2 талбай, цэцэрлэгт хүрээлэнгүүдийн 224,837.2 м2 талбайн цэвэрлэгээ үйлчилгээг тогтмол хийж, 80 м2 явган хүний замын засвар үйлчилгээ хийж, 25,000.0 ширхэг 6 төрлийн нэг наст цэгийн үрсэлгээг тарьж ургуулан шинээр 42 цацгийн мандлыг нэмэгдүүлэн хийж нийтийн эзэмшлийн талбайд шилжүүлэн тариалж, 3000ш мод бут сөөг, 2400 м2 талбайд нөхөн сэргээлт зүлэгжүүлэлт хийлээ.	Баянхонгор
7	71403	Ойжуулалт	416,395.5	405,756.4	97.44%	Шинээр тариалсан модны тоогоор	тоо	2023	248000	200000	200000	Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд 3281 м2 талбайд бургас 60,000.0, Улиас 40,000.0 ширхэг мөчрийн тайрдасын тарьц суулгаж тариалснаар 80-90%-ийн ургалттай байна. Мөн 6 нэр төрлийн 3.1кг үрийг хүлэмжид тариалж, шинэ суурьшлын бүсийн 15 га талбайд 2000ш бургас, 1500ш улиас нөхөн тариалалт хийсэн байна.	Баянхонгор
8	71413	Хүрээлэн буй орчны бодлого, удирдлага	1,661,279.8	1,570,971.4	94.56%	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	хувь	2023	85%	90%-иас дээш	92%	Баянхонгор аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар нь 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтээр аймгийн Засаг даргын тамгын газрын хяналт шинжилгээ үнэлгээний дүнгээр 91.86%-тай үнэлэгдсэн байна	Баянхонгор
9	71902	Нийгмийн халамж	168,454.2	123,438.2	73.28%	Үйлчилгээ үзүүлсэн иргэний тоо	тоо	2023	507	500	336	2025 онд Онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих тэтгэмжид 47 иргэнд 56.4 сая төгрөг, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд 289 иргэнд 65.2 сая төгрөг, хяналт шалгалт томилолтын зардалд 1,8 сая төгрөг нийт 336 иргэнд 123.4 сая төгрөг олгож ажилласан.	Баянхонгор
10	70503	Орон нутгийн зорилтот хөрөнгө оруулалт	34,638,775.4	23,064,332.8	66.59%	Хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний тоо	тоо	2023	41	54	42	2025 онд орон нутгийн хөгжлийг дэмжих аймгийн хөгжлийн тэнцвэртэй байдлыг хангах, иргэд тогтвор суурьшилтай амьдрах орчин, хөгжлийг бүрдүүлэх зорилгоор аймгийн төлөвлөсөн төсөв, сумдын ОНХСанг иргэдийн санал оролцоонд тулгуурлан 54 төсөл, арга хэмжээ 42 төсөл арга хэмжээг гүйцэтгэсэн байна	Баянхонгор

№	Хөтөл-Бөрийн код	Хөтөлбөрийн нэр	Батлагдсан төсөв	Төсвийн гүйцэтгэл	Төсвийн гүйцэтгэлийн %	Хөтөлбөрийн үр дүнгийн шалгуур үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Суурь он	Суурь түвшин	2025 оны зорилтот түвшин	Хүрсэн түвшин	Тайлбар	Аймаг
4	70426	Төрийн өмчийн эрхийг хэрэгжүүлэх	427,090.80	383,577.10	89.81%	Төрийн өмч ашиглалт, хамгаалалтыг сайжруулах, бодлогоор удирдлагаар хангах, Орон нутгийн өмчийн дуудлага худалдаа зохион байгуулах, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт	хувь	2024	98%	100.00%	97.10%	Орон нутгийн өмчийн газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 35 арга хэмжээ төлөвлөнөөс бүрэн хэрэгжсэн буюу 100%-тай 31, арга хэмжээний хүрэх түвшинд бүрэн хүрээгүй боловч зохион байгуулалтын арга хэмжээ бүрэн авадсан буюу 90%-тай 1, өөрсдөөс хамаарах шийдвэрийг гаргасан, санхүүгийн асуудал шийдвэрлэгдсэн, гүйцэтгэл тодорхой хэмжээгээр гарч эхлэж байна буюу 70%-тай 3 арга хэмжээ хэрэгжсэн бөгөөд дундаж биелэлтийн хувь 97.1% байна. 2024 онд өмч хувьчлалын орлогоос 50,000,000 төгрөг оруулахаар төлөвлөснөөс Аймгийн ИТХ-ын 2023 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 67 дугаар тогтоолоор 2024 онд 3 барилга байгууламж, 12 тээврийн хэрэгсэл худалдан борлуулах шийдвэр гарч мэргэжлийн үнэлгээний байгууллага болох "Виннэрвай үнэлгээ" ХХК-иар 3 барилга, 12 тээврийн хэрэгслийн үнэлгээг тогтоолон нээлттэй дуудлагын худалгааг зохион байгуулж 5 тээврийн хэрэгсэл, 2 барилга байгууламжийг худалдан борлуулж өмч хувьчлалын орлогын дансанд 269,000,000 төгрөгийг төвлөрүүлээд байна.	Говь-Алтай
						Аймгийн Орон нутгийн хөгжлийн сан, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, замын сангийн болон сумдын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх арга хэмжээг 100% хэрэгжүүлэх	хувь	2024	70.50%	90.00%	76.00%	Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 97 төсөл арга хэмжээг 9,518.9 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөснөөс 54 төсөл арга хэмжээг 4,676.1 сая төгрөгөөр санхүүжүүлж 49.1%-ийн хэрэгжилттэй бнэ. 2025 онд хэрэгжүүлэхээр төлөвлөгдсөн нийт төсөл арга хэмжээний 21 хувь нь 2026 онд дамжуулан хэрэгжүүлэхээр төлөвлөгдсөн. Мөн Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төв байгууллагаас хөрөнгө оруулалтын санхүүжилт олгох эрх хязгаарласантай холбоотойгоор үлдэгдэл санхүүжилт олгогдоогүй хүлээгдэж байна. ОНТХО-ын 7 ажил арга хэмжээг 1,280.8 сая төгрөгөөр санхүүжүүлэн хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 6 төсөл арга хэмжээг 980.6 сая төгрөгөөр санхүүжүүлж нийт аймгийн хэмжээнд 76% тай хэрэгжүүлсэн. 2025 онд хэрэгжүүлэхээр төлөвлөгдсөн нийт төсөл арга хэмжээний 24 хувь нь 2026 онд дамжуулан хэрэгжүүлэхээр төлөвлөгдсөн.	Говь-Алтай
5	70503	Орон нутгийн зорилгот хөрөнгө оруулалт	23,932,524.10	14,126,286.50	59.03%	Аймгийн Орон нутгийн хөгжлийн сан, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, замын сангийн болон сумдын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх арга хэмжээг 100% хэрэгжүүлэх	хувь	2024	70.50%	90.00%	76.00%	Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 97 төсөл арга хэмжээг 9,518.9 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөснөөс 54 төсөл арга хэмжээг 4,676.1 сая төгрөгөөр санхүүжүүлж 49.1%-ийн хэрэгжилттэй бнэ. 2025 онд хэрэгжүүлэхээр төлөвлөгдсөн нийт төсөл арга хэмжээний 21 хувь нь 2026 онд дамжуулан хэрэгжүүлэхээр төлөвлөгдсөн. Мөн Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төв байгууллагаас хөрөнгө оруулалтын санхүүжилт олгох эрх хязгаарласантай холбоотойгоор үлдэгдэл санхүүжилт олгогдоогүй хүлээгдэж байна. ОНТХО-ын 7 ажил арга хэмжээг 1,280.8 сая төгрөгөөр санхүүжүүлэн хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 6 төсөл арга хэмжээг 980.6 сая төгрөгөөр санхүүжүүлж нийт аймгийн хэмжээнд 76% тай хэрэгжүүлсэн. 2025 онд хэрэгжүүлэхээр төлөвлөгдсөн нийт төсөл арга хэмжээний 24 хувь нь 2026 онд дамжуулан хэрэгжүүлэхээр төлөвлөгдсөн.	Говь-Алтай
6	70801	Мал аж ахуйг хөгжүүлэх	556,820.00	408,904.00	73.44%	Санхүүжилт авсан мал эмнэлгийн үйлчилгээг үзүүлдэг аж ахуйн нэгж, олгосон зээл	тоо	2024	41	41	41.00	18 сумын мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлдэг 41 аж ахуй нэгжид 360,000.0 сая төгрөгийн санхүүжилт олгож малын эрүүл мэндийг хамгаалах үйл ажиллагааг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэн хэрэгжүүлсэн. Тайлант онд мал хамгаалах санааг 45,0 сая төгрөгийн зээл олгосон бөгөөд өмнө олгосон зээлийн гэрээний хэрэгжилтийг хянан шалгах ажлын шатахуун, албан томилолтын зардалд 3.9 сая төгрөг зарцуулсан.	Говь-Алтай

№	Хөтөл-Бөрийн код	Хөтөлбөрийн нэр	Батлагдсан төсөв	Төсвийн гүйцэтгэл	Төсвийн гүйцэтгэлийн %	Хөтөлбөрийн үр дүнгийн шалгуур үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Суурь он	Суурь түвшин	2025 оны зорилгот түвшин	Хүрсэн түвшин	Тайлбар	Аймаг	
7	70802	Газар тариалан хөгжүүлэх	50,000.00	795.00	1.59%	Газар тариалан эрхлэгч нэрт хөнгөлөлттэй зээл, үр тариа олгох, сангаас зээл авсан иргэдийн тоо	тоо	2024	0	5	0.00	Тайлант онд тариалан эрхлэлтийг дэмжих сангаас зээл авах хүсэлт ирээгүй байна.	Говь-Алтай	
8	71403	Ойжуулалт	318,671.30	292,952.20	91.93%	Зориудаар ойжуулах, байгалийн сэргэн ургалтыг дэмжихэд чиглэсэн үйл ажиллагааг идэвхжүүлэх, тарьсан мод, бут, сөөгний тоо	тоо	2024	4,025,100	3,000,000	3,112,167	Аймгийн нутгийн зөвлөл болон төрийн байгууллага, иргэдтэй хамтран 2025 онд хамгаалах зурваст 36167 ширхэг, төв суурин газарт 76000 ширхэг мод бут өсөг, Говийн их дархан цаазат газрын бус нутагт 3.0 сая ширхэг заг үрээр нийт 3,112.2 мянган ширхэг мод, заг тарьсан бөгөөд ургалт 80 хувьтай байна.	Говь-Алтай	
9	71411	Хүрээлэн буй орчин	1,847,988.80	1,702,186.40	92.11%	Байгаль орчны багц хууль болон дүрэм журам төрийн бодлого шийдвэрийг хэрэгжүүлэх, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт	хувь	2024	96.50%	100.00%	93.50%	Аймгийн Засаг даргатай байгуулсан 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт 93.5%-тай үнэлэгдсэн байна	Говь-Алтай	
10	71902	Нийгмийн хамгаалал	110,000.0	108,000.0	98.18%	100 иргэнд Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ, 40 иргэнд амьжиргааг дэмжих нөхцөлт мөнгөн тусламж үзүүлнэ	тоо	2024	133	140	143.0	Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээг төрийн бус байгууллагагай гэрээ байгуулж сургалт, зөвлөгөө мэдээлэл хийж чиглэлээр хамтран ажиллаж 52 иргэнд 7,004.0 мянган төгрөг, Олон нийтийн оролцоонд түшиглэсэн сэргэн засах үйлчилгээнд 36 иргэнд 10,395.5 сая төгрөг, бүлгийн төсөлд 24 бүлэгт 78.0 сая төгрөг, онцгой тохиолдлын мөнгөн тэтгэмж 31 иргэнд 27.6 сая төгрөгийг олгож ажилласан.	Говь-Алтай Говь-Алтай Говь-Алтай	
11	71602	Эмнэлэгийн тусламж үйлчилгээ	2,864,959.70	2,767,388.90	96.59%	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг санхүүжүүлж төрийн үйлчилгээг хэвийн явуулсан байгууллагын тоо	тоо	2024	19	19	19.0	Сумдын Эрүүл мэндийн төвүүдийн цахилгаан, дулаан, цэвэр бохир усны зардлыг бодит гүйцэтгэлд үндэслэн санхүүжүүлсэн.	Говь-Алтай	
12	71701	Биеийн тамир, спорт	418,183.80	416,183.80	99.52%	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг санхүүжүүлж төрийн үйлчилгээг хэвийн явуулсан байгууллагын тоо	тоо	2024	1	1	1.0	Биеийн тамир спортын газрын цахилгаан, дулаан, цэвэр бохир усны зардлыг бодит гүйцэтгэлд үндэслэн санхүүжүүлсэн.	Говь-Алтай	
13	71702	Соёл урлаг	2,258,009.40	2,207,556.10	97.77%	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг санхүүжүүлж төрийн үйлчилгээг хэвийн явуулсан байгууллагын тоо	тоо	2024	22	22	22.0	Аймгийн Орон нутгийг судлах музей, АДБ-ын Алтай чуулга, Нийтийн номын сан, сумдын соёлын төвийн барилгын цахилгаан, дулаан, цэвэр бохир усны зардлыг бодит гүйцэтгэлд үндэслэн санхүүжүүлсэн.	Говь-Алтай	
14	71801	Сургуулийн өмнөх боловсрол	2,083,203.10	1,938,110.30	93.04%	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг санхүүжүүлж төрийн үйлчилгээг хэвийн явуулсан байгууллагын тоо	тоо	2024	31	31	31.0	Аймгийн нийт сургуулийн өмнөх боловсролын цэцэрлэгүүдийн цахилгаан, дулаан, цэвэр бохир усны зардлыг бодит гүйцэтгэлд үндэслэн санхүүжүүлсэн.	Говь-Алтай	
15	71802	Ерөнхий боловсрол	8,441,310.20	7,864,274.70	93.16%	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг санхүүжүүлж төрийн үйлчилгээг хэвийн явуулсан байгууллагын тоо	тоо	2024	26	26	26.0	Аймгийн нийт ерөнхий боловсролын сургуулиудын цахилгаан, дулаан, цэвэр бохир усны зардлыг бодит гүйцэтгэлд үндэслэн санхүүжүүлсэн.	Говь-Алтай	
16	71804	Мэргэжлийн боловсрол	772,316.10	765,316.10	99.0936%	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг санхүүжүүлж төрийн үйлчилгээг хэвийн явуулсан байгууллагын тоо	тоо	2024	1	1	1.0	Аймгийн МСҮТ-ийн цахилгаан, дулаан, цэвэр бохир усны зардлыг бодит гүйцэтгэлд үндэслэн санхүүжүүлсэн.	Говь-Алтай	
17	71806	Эцэс хүүхдийн болон албан бус б	14,233.90	13,189.50	92.6626%	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг санхүүжүүлж төрийн үйлчилгээг хэвийн явуулсан байгууллагын тоо	тоо	2024	1	1	1	Аймгийн НТБТ-ийн цахилгаан, дулаан, цэвэр бохир усны зардлыг бодит гүйцэтгэлд үндэслэн санхүүжүүлсэн.	Говь-Алтай	
18	72101	Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих	2,976,346.00	990,082.50	33.2650%	Хоршоо хөгжүүлэх санд төлөвлөсөн зээл олголт	тоо	2024	485,114.4	2,247,647.5	985,000.0	Тайлант онд 2976.3 сая төгрөгийн зээл олгохоор төлөвлөсөн бөгөөд 39 иргэнд 985.0 сая төгрөгийн зээл олгосон.	Говь-Алтай	
						Зээлийн эргэн төлөлт	тоо	2024	1,065,515.1	1,000,000.0	1,265,500.0	2025 оны төсвийн жилд 1350.1 сая төгрөгийн зээлийн эргэн төлөлт төвлөрүүлэхээс 1265.5 сая төгрөг төвлөрүүлж 93.7%-ийн гүйцэтгэлтэй байна. Эргэн төлөлтийн мэдээллийг Монгол Банкнд тухай бүр илгээн ажиллаж байна.	Говь-Алтай	
<b>ДОРНОГОВЬ АЙМАГ</b>														
1	70105	Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын үйл ажиллагаа	5,561,818.20	5,062,542.53	91.02%	Нутгийн өөрөө удирдах байгууллагын талаарх иргэдийн сэтгэл ханамж	хувь	2023		70	85.0	Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын 2025 оны ажлын төлөвлөгөөнд 8 зорилт, 53 арга хэмжээнээс бүрэн хэрэгжсэн 53 арга хэмжээ, төлөвлөгөөний биелэлт 92 хувьтай хэрэгжсэн байна.	Дорноговь	
2	70709	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх	3,112,403.20	2,387,337.98	76.70%	Гэмт хэрэг, зөрчил	тоо	2024	677	600	692.0	Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн 2025 оны ажлын төлөвлөгөөнд тусгагдсан 5 зорилт, 51 арга хэмжээнээс бүрэн хэрэгжсэн 49 арга хэмжээ, төлөвлөгөөний биелэлт 96 хувьтай хэрэгжсэн байна.	Дорноговь	
3	70106	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	89,594,000.90	68,623,662.04	76.59%	Иргэдийн сэтгэл ханамж	хувь	2022		85.6	88	75.7	Монгол Улсын Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын даргын 2025 оны А/62 дугаар тушаалын дагуу аймгийн 2024 оны судалгааны үр дүнд 2024 оны үнэлгэний дунджийг 75.7%-тай үнэлсэн.	Дорноговь
4	70426	Төрийн өмчийг хэрэгжүүлэх	2,444,412.70	1,809,754.96	74.04%	Орон нутгийн өмчийн байгууллагын өмч хөрөнгийн ашиглалтын гэрээний хэрэгжилт	хувь	2024		82	90	81.0	Орон нутгийн өмчит байгууллагуудтай 2025 онд байгуулсан өмч эзэмшүүлэх гэрээг оны эцэст "Орон нутгийн өмчийг эзэмшүүлэх гэрээ байгуулах, дүнгээс журам"-ын дагуу орон нутгийн өмчит 146 байгууллагын гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж, үнэлж дүгнэв. Нийт 146 байгууллагаас 19 байгууллага сайн, 99 байгууллага хангалттай, 24 байгууллага хангалтгүй, 4 байгууллага огт дүнгүйлээгүй бөгөөд үнэлгээний дундаж 81.0 хувьтай байна.	Дорноговь
5	70418	Худалдан авах ажиллагаа	536,359.70	482,916.89	90.04%	Төлөвлөгөөний хэрэгжилт	хувь	2024		97.6	98	99.0	Тайлант онд Худалдан авах ажиллагааны газар 54.9 тэрбум төгрөгийн 52 төсөл арга хэмжээг төлөвлөн захиалагчаар батлуулснаас 52 төсөл арга хэмжээг давхардсан тоогоор 111 удаа зарлаж 48.2 тэрбум төгрөгийн 50 төсөл арга хэмжээний гүйцэтгэчийг сонгон шалгаруулж гэрээ байгуулах ажил олгосон. Дорноговь аймгийн 14 сум тайлант онд 21.6 тэрбум төгрөгийн 198 төсөл арга хэмжээний төлөвлөгөөг цахим системээр илгээж төсвийн өрөнхийлөн захирагчаар батлуулсан. Үүнээс 180 төсөл арга хэмжээг давхардсан тоогоор 224 удаа зарлаж 17.7 тэрбум төгрөгийн 155 төсөл арга хэмжээг шалгаруулж гүйцэтгэчтэй гэрээ байгуулсан.	Дорноговь

№	Хөтөл-Бөрийн код	Хөтөлбөрийн нэр	Батлагдсан төсөв	Төсвийн гүйцэтгэл	Төсвийн гүйцэтгэлийн %	Хөтөлбөрийн үр дүнгийн шалгуур үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Суурь он	Суурь түвшин	2025 оны зорилтот түвшин	Хүрсэн түвшин	Тайлбар	Аймаг
6	70429	Санхүүгийн хяналт, дотоод аудит, эрдсийн удирдлага	677,073.00	563,604.13	83.24%	Санхүүгийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	хувь	2023	627.7	450	713.0	Аймгийн Засаг даргаар батлуулсан Санхүүгийн хяналт шалгалтын 01 нэгдсэн удирдамжаар 68 байгууллагын үйл ажиллагаанд санхүүгийн хяналт шалгалт, 45 байгууллагын үйл ажиллагаанд дотоод аудит хийхээр төлөвлөгдсөнөөс тайлант хугацаанд 36 байгууллагын үйл ажиллагаанд санхүүгийн хяналт шалгалт, 26 байгууллагын үйл ажиллагаанд дотоод аудит хийж төлөвлөлийн бэлгэлтийг 74.3 хувьтай хэрэгжүүлж ажилласан. Тайлант хугацаанд 917.7 сая төгрөгийн 713 эрчил, дутагдал илрүүлж, улсын ахлах байцаагчийн 222 акт тогтоон, хугацаатай албан шаардлага 29-ийг бичиж, 954 зөвлөмжийг хүргүүлсэн. 2025 онд тогтоогдсон 917.7 сая төгрөгийн акты төлбөрийн барагдуулалт 71.5 хувь буюу 656,0 сая төгрөгийг барагдуулсан байна. Үүнээс орон нутгийн төсвийн орлогын дансанд 16.5 хувь буюу 108.5 сая төгрөгийг төвлөрүүлж, өгөгдсөн зөвлөмжийн хэрэгжилтийг 91.5 хувьтай хангуулсан.	Дорноговь
7	71411	Хүрээлэн буй орчны бодлого, удирдлага	3,646,926.00	2,725,742.55	74.74%	Салбарын тогтоол шийдвэрийн хэрэгжилт	хувь	2023	24	30	78.2	Байгаль орчныг хамгаалах, хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх, нөхөн сэргээлтийг стандартад нийцүүлэх, биологийн төрөл зүйлийг хамгаалах, тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг өргөтгөх, байгалийн нөөцийг зохицой ашиглах, ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг олгох, цуцлахад иргэдийн оролцоог хангах, гадаргын усны нөөцийг нэмэгдүүлэх, хүн амын ундны ус, булаг, шанд, рашааныг хамгаалах, агаар орчны бохирдлыг бууруулах, хог хаягдлыг бууруулах, ангилан ялгах бодлогын хүрээнд салбарын бодлогын баримт бичгүүдийн холбогдох арга хэмжээндүүдийг 78.2%-тай хэрэгжүүлж ажилласан.	Дорноговь
8	71405	Тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалт	984,627.50	984,627.50	100.00%	Тусгай хамгаалалт авсан газрын хэмжээ	га	2023	34.5	35	35.0	Монгол Улсад тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг өргөтгөх, менежментийг сайжруулах ажлыг хэрэгжүүлж, аймгийн хэмжээнд тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээ нийт нутаг дэвсгэрийн 33 хувьд хүрлээ. Дэлгэрэх сумын "Шар мод", Айраг сумын "Майхан дэл", "Хүрэн өндөр", "Үйзэн", "Баруун цагаан дэл", "Гашуун говь", "Хондлой ухаа", "Дэлгэрэх" зэрэг газруудыг нийт 67,016.33 га талбайг орон нутгийн тусгай хамгаалалтад авсан. 2019 оны Монгол Улсын Их Хурлын 41 дүгээр тогтоолоор Айраг сумын Цагаан дэлийн агуй, Хөвсгөл сумын "Гүн гашууны хоолой"-г улсын тусгай хамгаалалтад авч, Засгийн газрын 2025 оны 106 дугаар тогтоолоор Цагаан дэлийн агуй 116.01 га, Гүн гашууны хоолой 64,911.31 га талбайтайгаар баталгаажсан. Мөн 2025 онд Эрдэнэ сумын Цант хайрхан-модонгийн худаг 6,855.37 га талбайг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрээр орон нутгийн тусгай хамгаалалтад авч, Ашигт малтмал, газрын тосны газарт бүртгүүлсэн.	Дорноговь
9	71413	Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх	2,930,838.50	1,510,849.35	51.55%	Нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдсан иргэд	тоо	2023	95	97	86.5	Аймгийн Засаг даргын "Тогтвортой бодлого-Тасралтгүй хөгжил" 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр байгаль орчныг хамгаалах, хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх, нөхөн сэргээлтийг стандартад нийцүүлэх, биологийн төрөл зүйлийг хамгаалах, тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг өргөтгөх, байгалийн нөөцийг зохицой ашиглах, ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг олгох, цуцлахад иргэдийн оролцоог хангах, гадаргын усны нөөцийг нэмэгдүүлэх, хүн амын ундны ус, булаг, шанд, рашааныг хамгаалах, агаар орчны бохирдлыг бууруулах, хог хаягдлыг бууруулах, ангилан ялгах бодлогын хүрээнд 30 арга хэмжээг тусгаж, жилийн эцсийн дунджыг 86.5%-тай хэрэгжүүлсэн.	Дорноговь
10	71902	Нийгмийн халамж	159,400.00	93,790.00	58.84%	Нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдсан иргэд	тоо	2023	95	97	98.0	"Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний Нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрх, иргэний нийгэмшүүлэх, хамт олны бүлэг бүрдүүлэх, орлогын эх үүсвэртэй болгох төсөл хэрэгжүүлэх, амьдрах ухаанд сургах үйлчилгээ үзүүлэх аж ахуй нэгж, төрийн бус байгууллага сонгон шалгаруулах тендерийг 2025 оны 08 дугаар сарын 26-ны өдөр ДГАХХҮГ/20250203019 урилгын дугаартай зарласан. Тус тендер нээх хугацаанд "Насан туршийн суралцахуйн төв", "Хөдөлмөрийн их сургууль", "Монголын удирдлага шинэчлэлийн академий" гэсэн 3 байгууллага үнийн санал ирүүлсэн. Үнэлгээний хорооны гишүүд хуралдан "Насан туршийн суралцахуйн төв"-ийг "Хамгийн сайн" үнэлэгдсэн тендерээр шалгаруулж 49.2 сая төгрөгөөр гэрээ байгуулах эрх олгосон. Гэрээний дагуу төсөл хэрэгжүүлэх, амьдрах ухаанд сургах 4 төрлийн сургалтыг 50 иргэнд зохион байгуулж байгаа бөгөөд цаашид өрхийн үйлдвэрлэл эрхлэх сонирхолтой 20 өрхөд 36.0 сая төгрөгийг тусламж, гэрээт байгууллагад 11.1 сая төгрөг, нийт 47.1 сая төгрөгийн санхүүжилтийг, Амьжиргаа дэмжих мөнгөн тэтгэмжид хамрагдах хүсэлт гаргасан 28 иргэнд 33.6 сая төгрөгийг нийт 80.7 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс олгосон.	Дорноговь
11	71600	Эрүүл мэнд	7,507,264.50	6,201,637.47	82.61%	Эрт илрүүлгийн үзлэгт хамрагдалт	хувь	2023	48.1	55	51.9	Хувь хүн, гэр бүл, хамт олонд эрүүл зан үйл төлөвшүүлэх, эрүүл мэндийн боловсрол олгох зорилгоор 1203 удаагийн аян, өдөрлөг, тэмцээн, уралдаан, сургалт зохион байгуулж, давхардсан тоогоор 32563 иргэний хамруулан 139 төрлийн 1785 зөвлөмж тарааж, цахимгаар 576 төрлийн мэдээлэл, телевизэд 72 нэвтрүүлэг бэлтгэн түгээж, нийт 130483 хандалт авсан нь өмнөх оноос 298 арга хэмжээ, 9687 хүнээр нэмэгдэж, эрүүл мэнддээ анхаарах иргэдийн хандлагыг сайжруулснаар урьдчилан сэргийлэх эрт илрүүлэх үзлэгийн хувь 51.9%-д хүрч, өмнөх оны мөн үеэс 3.3%-иар өссөн. Тайлант онд 826 эх төрснөөр өмнөх оноос 139 тохиолдол буюу 17.5%-иар буурч, 0-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 1000 амьд төрөлтөд 19.7-д хүрч, өмнөх оноос 3.8-аар өссөн нь улс аймгийн дунджаас 7.9-8-аар доогуур үзүүлэлттэй байна. Эхийн эндэгдлийн 1 тохиолдол бүртгэгдэж 100,000 амьд төрөлтөд 116.0-д хүрч, хариу арга хэмжээг хэрэгжүүлэн, үр дүнг тооцож, алдааг дахин гаргахгүй байхад анхаарч ажиллаж байна. Аймгийн хэмжээнд 2025 онд эрүүл мэндийн салбарт 1 өргөтгөл, 1 шинэ барилга барихаар төлөвлөсөн. Тайлант оны жилийн эцсийн байдлаар: 1.Орон нутгийн төсвийн 1,124.1 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Өргөн сумын эрүүл мэндийн төвийн барилгын өргөтгөлийн ажлыг хийж гүйцэтгэх тендерт "Дэнжийн хүү" ХХК шалгарч, 2025 оны 06 дугаар сарын 04-ний өдөр гэрээ байгуулан, 11 сарын байдлаар дулааны шугамын ажил 70%-ийн гүйцэтгэлтэй, хүйтний улиралд гадна ажил хийхэд барилгын чанарт нөлөөлөх тул ирэх оны 03 дугаар сараас эхлэн үргэлжлүүлэхээр түр зогсоосон.2.Хүн амын дунд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмж, чанарыг сайжруулах зорилгоор Монгол Улсын Засгийн газар, Азийн Хөгжлийн Банктай хамтран "Эмзэг бүлгийн иргэдийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг сайжруулах хөрөнгө оруулалтын хөтөлбөр" хөнгөлөлттэй зээлийн хүрээнд Эрдэнэ сумын эрүүл мэндийн төвд 4600.0 сая төгрөгийн шинэ барилга барих ажил 2024 онд эхэлж, 2025 оны жилийн эцсийн байдлаар 90%-ийн гүйцэтгэлтэй байна. Аймгийн Засаг даргын 2025 оны А/376 дугаар захирамжийн дагуу 13.1 сая төгрөгийн дэмжлэгтэйгээр "Явуулын амбулаторийн үзлэг 2025" арга хэмжээг зохион байгуулж, хуваарийн дагуу аймгийн Нэгдсэн эмнэлэг, Замын-Үүд сумын Нэгдсэн эмнэлэг, Уламжлалт анагаах ухааны нэгдсэн эмнэлэг хамтран дотор, хүүхэд, мэдрэл, эмэгтэйчүүд, арьс, чих хамар хоолой, ЭХО, уламжлалт анагаах ухаан, мэс засал, лаборатори зэрэг 12 төрлөөр 10 эмч, мэргэжилтнүүдээс бүрдсэн баг 13 суманд ажилласан. Үзлэгт нийт 6252 иргэний хамруулан, давхардсан тоогоор 11737 үзлэг, шинжилгээ хийсэн нь өмнөх оноос 245 хүнээр нэмэгдэж, 128 шинэ өвчлөл илрүүлсэнээс 83.3% нь орон нутагтаа эмчлэгдэн эрүүлжж, 16.7% нь онош тодруулах зорилгоор лавлагаа шатлалын эмнэлэгт шилжүүлсэн. Хавдарын сэжигтэй 4 тохиолдлыг илрүүлэн, лавлагаа шатлалын эмнэлэгт онош тодруулахад хавдрын урьдал 2, хорт хавдар 2 батлагдсан эмчлүүлж байна.	Дорноговь

№	Хөтөл-Бөрийн код	Хөтөлбөрийн нэр	Батлагдсан төсөв	Төсвийн гүйцэтгэл	Төсвийн гүйцэтгэлийн %	Хөтөлбөрийн үр дүнгийн шалгуур үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Суурь он	Суурь түвшин	2025 оны зорилтот түвшин	Хүрсэн түвшин	Тайлбар	Аймаг
12	71701	Биеийн тамир, спорт	2,311,371.80	1,940,320.34	83.95%	Спортлоо хичээллэгсад	хүн	2022	15000	16000	27392.0	Тайлант онд 117 спортын арга хэмжээг зохион байгуулж, спортын үйл ажиллагаанд 27392 иргэний хамрагдсан. Хүн амыг хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх, эрүүл, идэвхтэй зан үйлийг төлөвшүүлэх зорилгоор Говийн бүсийн "Иргэдийн спортын их наадамд" 4 аймгийн 800 гаруй тамирчин оролцож 40,0 сая төгрөг зарцуулсан. "Сайншанд марафон-2025", уулын дугуйн тэмцээн, хүүхдүүдийн марафон тэмцээнд нийтдээ 1848 тамирчин, флаш моб, хийн дасгал, ажлын байрны түмэн дасгал, явган алхалт, шугаман болон нийтийн бүжиг зэрэгт 5202 иргэн хамрагдсан.	Дорноговь
13	71702	Соёл урлаг	10,104,776.00	6,937,930.00	68.66%	Соёл урлагийн үйлчилгээний хүртээмж	хувь	2023	150	155	157.3	Аймгийн хэмжээнд 2025 онд соёлын урлагийн үйлчилгээг давхардсан тоогоор 157,376 иргэнд хүргэж ажиллалаа. Соёл урлагийн 55 удаагийн арга хэмжээг зохион байгуулж, шинээр 1 уран бүтээл туурвисан.	Дорноговь
14	71801	Сургуулийн өмнөх боловсрол	4,758,806.00	3,963,311.79	83.28%	СӨБ-ын хамран сургалтын бохир жин	хувь	2024	97.2	97.3	98.4	Төсөл, хөтөлбөрийн хүрээнд орон нутгийн төсвийн нийт 330.9 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 35 цэцэрлэгийг STEAM сургалтын хэрэгслэгдүүнээр хангаж давхардсан тоогоор 544 сургалт, үйл ажиллагаанд 10670 суралцагчийг хамруулсан. Намалтээр 3966 ширхэг сургалтын материал олшруулж сургалт, үйл ажиллагаанд ашигласан. Аймгийн Засаг даргын 2025 оны А/79 дүгээр захирамжаар орон нутгийн төсвийн 272.7 сая төгрөгөөр "Сүү" хөтөлбөрийг санхүүжүүлж төрийн өмчийн цэцэрлэгийн суралцагчийг 100% хамруулсан. Мөн орон нутгийн аж ахуйн нэгжүүдийг дэмжин хамтран ажиллаж, төвийн 13 цэцэрлэгийн 2151 суралцагч, төмөр замын цэцэрлэгийн 193 суралцагчид 7 хоногт хүхэд бүрт 1 удаа 50 мл-ээр ингэний сүүг "Хашаатын говийн заг" ХХК-иас нийлүүлдэг. Бусад өдрүүдэд "Өгөөж эрдэнэ дэлгэрэх" ХХК, "Цагаан сүүний буян" ХХК, "Борхойн сүү" ХХК-иуд хэрэгцээг сүүг нийлүүлж ажилласан. Үр дүнд суралцагчдын дархлаа сайжирч, кальцийн хэрэглээ нэмэгдэж, шүдний өвчлөл 4-3%, өндрийн үзүүлэлтэд хүрэхгүй байгаа хүүхдийн тоо 0.5% болж буурсан. Аймгийн цэцэрлэгийн гал тогооны тоног төхөөрөмжийг "Чиглэл" ХХК шалгарч гэрээ байгуулсны дагуу багц 1-ийн 6 нэр төрлийн 59 ширхэг 293,7 сая төгрөгийн гал тогооны тоног төхөөрөмжийг нийлүүлсэн. Орон нутгийн болон олон улсын байгууллагын хөрөнгө оруулалтаар нийт боловсролын салбарын 55 байгууллагын гал тогоонд нэн шаардлагатай 33 нэр төрлийн 258 ширхэг 674,4 сая төгрөгийн тоног төхөөрөмжөөр хангасан.	Дорноговь
15	71802	Ерөнхий боловсрол	13,083,545.60	10,112,551.97	77.29%	Сурагчийн гүйцэтгэлийн үнэлгээний дундаж хувь	хувь	2024	55.1	55.5	49.8	Аймгийн Засаг даргын 2025 оны А/81 дүгээр захирамжаар "Үдийн хоол" хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд орон нутгийн төсвийн 926.6 сая төгрөгийг шийдвэрлэсэн ба "Үдийн хоол"-ыг ерөнхий боловсролын 22 сургууль өөрийн цайны газарт балтган ажиллаж байна. "Үдийн хоол" хөтөлбөрийг аймгийн хэмжээний ерөнхий боловсролын 22 сургуулийн 6-9 дүгээр ангийн нийт 5977 суралцагчийг хамруулан хэрэгжүүлээ. Хөтөлбөрийн хэрэгжилтийн явцын сэтгэл ханамжийн судалгааг 2025 оны 04 дүгээр сар болон 09 дүгээр сард авч, ерөнхий боловсролын 22 сургуулийн нийт 4563 суралцагч, 4520 эцэг эх, асран хамгаалагчийг хамруулсан. Аймгийн Засаг даргын 2025 оны А/80 дугаар захирамжаар 40.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлж цэцэрлэг, сургуулийн 1100 багш, ажилтанд "Багшийн хөгжил-сургалтын арга зүй" танхимын сургалт, зөвлөх болон тэргүүлэх зэрэгтэй 21 бага боловсролын багшийг ерөнхий боловсролын сургуульд "Ментор багш"-аар салган ажиллуулах, багшийн хөгжил хариуцсан 21 сургалтын менежерийг чадавхжуулах сургалт, сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургуульд 5, 10, 15, 20 дахь жилдээ ажиллаж байгаа 126 багш, 2, 7, 12 жилдээ ажиллаж байгаа сургууль, цэцэрлэгийн 19 удирдах ажилтан хамрагдаж эргэцүүлэлд суурилсан багшдад, суралцагчийн мэдлэг чадвараа дээшлүүлээ. 2025 онд говийн бүсийн хэмжээнд өргөжүүлэн аймгийн Засаг даргын 2025 оны А/641, А/642, А/643 дугаар захирамжаар 95.6 сая, Нутгийн зөвлөлийн санхүүжилт 120.0 сая, нийт 215.6 сая төгрөгийг зарцуулж 9 төрлөөр Өмнөговь, Дундговь, Говьсүмбэр, Дорноговь аймгийн 83 баг, хамт олныг оролцууллаа. "Шилдэг эцэг, эхийн зөвлөл, сургуулийн зөвлөл"-өөр Дорноговь аймгийн Хөвсгөл сумын ерөнхий боловсролын сургууль, "Суурь боловсролын шилдэг сургууль"-иар Дорноговь аймгийн Улаанбадрах сумын ерөнхий боловсролын сургууль, "Бүрэн дунд боловсролын шилдэг сургууль"-иар Дорноговь аймгийн Сайншанд сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль тус тус шалгарсан. Аймгийн ИТХ-ын даргын 2025 оны 88 дугаар захирамжаар 2.0 сая төгрөг, Хүүхэд хамгаалал, гэр бүл хөгжлийн газрын даргын 2025 оны А/21 дугаар тушаалаар 1.5 сая төгрөг болон бусад байгууллагуудын дэмжлэгээр нийт 6.9 сая төгрөг зарцуулсан. "Дорноговь робот-2025" өсвөрийн зохион бүтээгчдийн тэмцээнийг "Миниробот", "Ардуино робот" гэсэн үндсэн 2 төрөл, 5 насны ангиллаар амжилттай зохион байгууллаа.	Дорноговь
16	71804	Мэргэжлийн боловсрол	290,379.40	274,364.88	94.48%	МСУТ-д суралцагчид	тоо	2024	783	790	885.0	Политехник коллежид 2025-2026 оны хичээлд Механиксын тээврийн хэрэгсэл механизмын засвар үйлчилгээ, Цахилгаан хангамж, тоног төхөөрөмжийн ашиглалт, Хосолны үйлчилгээ, Барилгын бүтээц, усралт, Гангуур, Гар урлал, Механик, Хэвлэлийн график дизайны, бүтээгдэхүүн, Өмнөл бүтээгдэхүүн үйлдвэрлэл, Хүлэмжийн аж ахуй, Бүртгэл тооцоо хөтөлөлт, Уул, уурхайн ашиглалт, Галт тэрэгний ашиглалт, засвар үйлчилгээ, Төмөр замын барилга, зам, замын ашиглалт, Төмөр замын тээврийн удирдлага, зохион байгуулалт, Зорчигч болон ачаа тээврийн үйлчилгээ, Барилгын техник, технологи, Цахилгаан хангамж, тоног төхөөрөмжийн ашиглалт гэсэн 18 мэргэжлээр 885 суралцагч суралцаж байна.	Дорноговь
17	70801	Мал аж ахуйн хөгжүүлэх	766,894.90	472,416.27	61.60%	Мал, амьтны өвчлөлийн бууралт	хувь	2024	2	2.5	2.0	2025 онд малын гоц халдварт, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор 14 суманд масс идэвхтэй болон идэвхгүй тандалт, судалгааг тогтмолжуулж зохион байгуулсан. Идэвхтэй үзлэгт 3026 өрхийн 1,367 мянган толгой бог мал, идэвхгүй үзлэгт 311 өрхийн 111.5 мянган толгой мал, нийт 3,337 өрхийн 1,478.5 мянган толгой мал хамрагдав. Бог малын мялан, хонины цэцэг, ямааны гадран өвчний идэвхгүй тандалтад 7137 өрх хамрагдаж, халдварт өвчний эрт илрүүлийн идэвхтэй тандалтад 151 өрхийн 94,183 мал хамрагдаж, 5.4 сая төгрөг зарцуулсан. Оролцоот эпидемиологийн аргачлалаар идэвхтэй тандалтад 206 малчин, 105,071 мал хамрагдаж, 7.9 сая төгрөг зарцуулсан. Айраг, Иххэт суманд шүлхий өвчний тархалтаас урьдчилан сэргийлэх тандалтад 101,711 мал хамрагдаж, өвчний шинж тэмдэг илрээгүй. Мал, амьтны гаралтай түүхий эд бүтээгдэхүүнд 1-4 удаагийн хяналт шинжилгээгээр 7,670 өндөг, 137,648 тн мах, 1.4 тн цагаан идээ эрүүл, аюулгүй болохыг баталгаажуулсан. Молекул биологи, хүнд металл, шингээх судаллын шинжилгээнд 65 эмзэгт материал ирж, 17 өвчин оношлогдсон. Адууны ям, африк мялан, халдварт цус гадагш өвчний тандалтад 140 адуу хамрагдаж, 2 адуунд ям өвчин илэрч хариу арга хэмжээ авч хэрэгжүүлсэн. Шүлхий өвчний тандалтад 960 мал хамрагдаж, 1% халдвар илэрснийг давтан шинжилгээнд хамруулахад шинжилгээний хариу сөрөг дүнтэй гарсан. Энэ нь өмнөх онтой харьцуулахад 50%-иар буурсан. Бруцеллөз өвчний тандалтад 11,200 дээжний шинжилж бүгд сөрөг дүнтэй гарсан. Тандалт, судалгааны ажилд нийтдээ 57.9 сая төгрөг зарцуулж, 14 сумын 28 мал эмнэлгийн үйлчилгээний нэгжид 33,600 хэрэглэгдэхүүн тарааж, мал эмнэлгийн тандалт, шинжилгээ, судалгааг тогтмол зохион байгуулж байна.	Дорноговь
18	70708	Гамшгаас хамгаалах	7,290,558.40	4,423,777.04	60.68%	Гамшгийн эрсдэлийн ерөнхий болон нарийвчилсан үнэлгээний хувь	хувь	2024	10	15	15.0	Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 190 дүгээр тогтоолоор батлагдсан "Гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх журам", Монгол улсын Шадар сайдын 2021 оны 68 дугаар тушаалаар батлагдсан "Гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх заавар"-ын дагуу тайлант хугацаанд Дорноговь аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хэмжээнд Ган, зуд, үер, хэзрийн туймэр, хүнтэй салхи, шуурга зэрэг нийт 5 төрлөөр холбогдох байгууллагуудтай хамтран гамшигын эрсдэлийн ерөнхий үнэлгээ хийсэн.	Дорноговь

№	Хөтөл-Бөрийн код	Хөтөлбөрийн нэр	Батлагдсан төсөв	Төсвийн гүйцэтгэл	Төсвийн гүйцэтгэлийн %	Хөтөлбөрийн үр дүнгийн шалгуур үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Суурь он	Суурь түвшин	2025 оны зорилтот түвшин	Хүрсэн түвшин	Тайлбар	Аймаг
19	72208	Ахмад настны хөгжил, хамгаалал	225,344.60	163,890.62	72.73%	Төрийн үйлчилгээнд хамрагдсан ахмадын тоо	тоо	2023	28	30	5380.0	Ахмад настны хөгжил оролцоог дэмжих, нийгмийн амьдралд идэвхтэй оролцох нөхцөлийг бүрдүүлэн аймгийн хэмжээнд нийт 1 ордон, 14 өргөө, 25 танхим үйл ажиллагаагаа тогтмол явуулж байгаа бөгөөд урсгал зардал, тоног төхөөрөмжийг тухайн орон нутгийн төсөвт тусгасан. Аймгийн Засаг даргын 2025 оны А/128 дугаар захирамжаар 70.4 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон. Тайлант хугацаанд 14 салбар хороо 34 төрлийн үйл ажиллагааг зохион байгуулж, 5380 ахмад настан хөгжлийн үйлчилгээнд хамрагдсан.	Дорноговь
20	71101	Автозам	3,160,953.90	1,888,655.45	59.75%	Хэрэгжүүлсэн арга хэмжээ	тоо	2024	22	10	11.0	Орон нутгийн төсвийн 175.9 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Сайншанд сумын 7 дугаар баг "Тэс петролиум" ШТС-ын 3-н замын уулзаарын тойргийн өргөтгөл хийж авто зам барих ажлын тендерт "Дэлгэр баясах зам" ХХК шалгаран гүйцэтгэж 2024 оны 06 сард ашиглалтад оруулсан. Тус ажлын санхүүжилтийг 2024-2025 онд санхүүжүүлэхээр аймгийн 2024 оны төсөвт баталсан тул гэрээний дагуу 2024 онд 119.4 сая төгрөгийг, 2025 онд 56.5 сая төгрөгийг санхүүжилтийг тус тус олгосон. Орон нутгийн төсвийн 313.4 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Сайншанд сумын 7-р баг "Гор газ" ШТС-ын уулзаараас баруун тийш үргэлжлэх авто замаас "Мандах наран-5 хороолол" хүртэлх 0.16 км авто замын барилга угсралтын ажлыг "Дэлгэр баясах зам" ХХК гүйцэтгэж 2024 оны 06 сард ашиглалтад оруулсан. Тус ажлын санхүүжилтийг 2024-2025 онд санхүүжүүлэхээр аймгийн 2024 оны төсөвт баталсан тул гэрээний дагуу 2024 онд 230.0 сая төгрөгийг, 2025 онд 83.4 сая төгрөгийг санхүүжилтийг тус тус олгосон.	Дорноговь
21	70203	Засгийн газрын өрийн үйлчилгээ	506,047.40	-	0.00%	Өр барагдуулалт	хувь	2023	53	100	0.0		Дорноговь
22	70204	Санхүүгийн зах зээлийн зохицуулалт	200,000.00	-	0.00%	Зах зээлийн үнээс хямд	тн	2023	50	-2000	-2000.0	2025 онд аймгийн сумдад махны чиглэлийн эрчимжсэн мал аж ахуйг дэмжих чиглэлээр арга хэмжээ авлаа. "Атар 4" хөтөлбөрийн хүрээнд хүүгийн дэмжлэгтэй хөнгөлөлттэй зээлээр "Товийн амт трейд" ХХК махны чиглэлийн герефорд үхдрийн 65 тугалтай үнээ, 2 хээлтүүлэгч, 2 өсвөр хээлтэгч авч, төслийн гүйцэтгэл 90%-тай үргэлжилж байна. Мөн "Шинэ хороо" хөдөлгөөний хүрээнд Сайншанд, Улаанбадрах сумдын 2 хороонд мах, сүүний чиглэлийн эрчимжсэн мал аж ахуй эрхлэхэд 100.0 сая төгрөгийг хөнгөлөлттэй зээл олгож дэмжлэг үзүүлсэн. Аймгийн хэмжээнд мах, сүүний чиглэлийн эрчимжсэн мал аж ахуй эрхлэгч 10 иргэн, махны чиглэлийн эрчимжсэн мал аж ахуй эрхлэгч 4 иргэн, 1 аж ахуй нэгж, нийт 15 иргэн, ААН үйл ажиллагаа эрхэлж, жилд дунджаар 8.1 тн махыг зах зээлд нийлүүлж байна.	Дорноговь
23	70601	Зэвсэгт хүчний үйл ажиллагаа	267,563.00	267,563.00	100.00%	Хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээ	хувь	2024	8	4	4.0	2025 онд Зэвсэгт хүчний 336, 065 дугаар ангидунорин нөхцлийг сайжруулах зорилгоор 267.5 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын ажил хийгдсэн. Ажлын гүйцэтгэл 100%	Дорноговь
24	70602	Хил хамгаалах	160,000.00	160,000.00	100.00%	Хил хамгаалах байгууллагуудтай хамтран зохион байгуулсан ажил	тоо	2023	6	6	6.0	Хил хамгаалалтад туслах хүчний орон тооны бүс зөвлөлийн зөвлөгөөнийг 2024 оны 10 дугаар сард Сайншанд суманд зохион байгуулж, уг зөвлөгөөнөөр 2024 онд хийсэн ажлыг тайлагнан, 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан батлуулсан. Төлөвлөгөөнд нийт 5 зорилт, 19 арга хэмжээг тусган, хэрэгжилтийг 94 хувийн гүйцэтгэлтэй ханган ажилласан. Орон нутгийн төсвөөс хил хамгаалах байгууллагын үйл ажиллагааг дэмжиж, хилчдийн ажиллаж амьдрах нөхцөлийг сайжруулах, иргэд, хүүхэд, залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх ажлыг хамтран зохион байгуулж, нийт 160.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн. Хилийн цэргийн 0129 дүгээр ангид Хил хамгаалалтад туслах хүчний салбар зөвлөлийн 2025 оны зөвлөгөөнийг зохион байгуулсан. Мөн Хилийн цэргийн дуу, бүжгийн чуулгын 16 хүний бүрэлдэхүүнтэй уран бүтээлчид 2025 оны I улиралд хилийн цэргийн 3 анги болон хил хамгаалалтад туслах хүчний зөвлөлийн гишүүдэд сэтгэл зүйн бэлтгэл олгох, соён гэгээрүүлэх, сургалт, нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулсан. Аймгийн Засаг даргын 2025 оны А/376 дугаар захирамжийн дагуу "Явуулын амбулаторийн үзлэг"-ийг хилийн бүсийн сумдад зохион байгуулж, алба хаагчид болон тэдний гэр бүлийн гишүүдийг урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоонд хамруулан, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлсэн. Түүнчлэн Хилийн цэргийн 0168 дугаар ангийн хяналтын төвийн тохиожилтын ажил орон нутгийн төсвөөс 80.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлснээр хилийн 8 салбарт "Хяналтын төв" байгуулж, улсын хил хамгаалалтын удирдлагын холбоо, мэдээллийн нэгдсэн системд холбосон. Ингэснээр хяналтын үйл ажиллагааг төвлөрүүлж, хил орчмын аюулгүй байдал, эрсдэлийг шуурхай илрүүлэх, мэдээлэх чадавч нэмэгдсэн. Улсын хилийн халдашгүй дархан байдлыг хангах, хилийн болон хил орчмын дэглэмийг сахиулах, хил хамгаалалтад иргэн, байгууллагын оролцоог нэмэгдүүлэх зорилгоор Дорноговь аймгийн Хил хамгаалалтад туслах хүчний зөвлөлийн зөвлөгөөнийг 2025 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр Хилийн цэргийн 0129 дүгээр ангид зохион байгуулж, Замын-Үүд, Улаанбадрах, Хатанбулаг, Эрдэнэ сумдын удирдлага болон зөвлөлийн гишүүд зэрэг нийт 50 хүнийг хамруулсан.	Дорноговь
25	71502	Хот байгуулалт, тохижилт	23,133,881.40	15,938,124.88	68.90%	Хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээ	тоо	2023	56	31	30.0	Замын-Үүд сумын Совмбо багийн нутаг дэвсгэрт "Мандах наран-6" орон сууцны хороолол барих төслийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 144 айлын орон сууц нь "Түрээсийн орон сууц"-ны ангиллаар төлөвлөгдөж, орон нутгийн хөгжлийн сангийн 16 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар "Түрээсийн орон сууц хөтөлбөр хэрэгжүүлэх" ажлын тендерт "Антугла трейд" ХХК шалгарч, 9 давхар 4 блок 288 айлын орон сууцны барилгыг 2025 оны 10 дугаар сарын 02-ны өдөр ашиглалтад оруулж Аймгийн ИТХ-ын 2023 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 12/02, 12/03 дугаар тогтоолоор "Дорноговь аймгийн зорилтот бүлгийн иргэдийг түрээслэд өмчлөх орон сууцанд хамруулах журам"-ын дагуу түрээсийн орон сууцанд хамрагдах 792 иргэний хүсэлтийг хүлээн авч, шалгаруулалтыг удирдан зохион байгуулах аймгийн Засаг даргын А/610 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг Замын-Үүд суманд ажиллаж, 105 айлын орон сууцыг зорилтот бүлгийн иргэдэд, журмын дагуу олгосноос 27 иргэн нь залуучуудын насны иргэд байна. Монгол Улсын Их Хурлаас баталсан Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, Засгийн газраас хэрэгжүүлж буй "Шинэ сэргэлтийн бодлого", Дорноговь аймгийн Засаг даргын "Тогтвортой бодлого-Тасралтгүй хөгжил" 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлж 2025 оны 05 дугаар сарын 11-ний өдөр "Сигл апартамент" залуусын түрээсийн орон сууцны шавыг тавилаа. Уг орон сууцанд орон нутагт ажиллахаар ирсэн ганц бие залуучууд болон гэр бүлд 5 жил хүртэл хугацаатайгаар түрээслэн амьдарч болох бөгөөд энэ хугацаанд байрны урьдчилгаа мөнгөн хуримтлалыг үүсгэн ипотекийн зээлд хамрагдах замаар орон сууцны асуудлаа шийдвэрлэх боломжийг бүрдүүлсэн. Сайншанд сумын Захирагчийн ажлын албыг шаардлагатай машин механизмаар хангах хүрээнд аймгийн орон нутгийн төсвийн санхүүжилтээр хот тохижилтын үйл ажиллагааг дэмжих хоёр үндсэн худалдан авалтын ажил хийгдсэн. Нийт 445,3 сая төгрөгийн санхүүжилтээр зам цэвэрлэгээний автомашиныг 2025 оны 09 дүгээр сарын 11-ний өдөр Сайншанд тохижилт үйлчилгээний газарт "Егу говь" ХХК, Мөн 324.5 сая төгрөгийн санхүүжилтээр ковш машин нийлүүлэх ажлыг "Монтех дистрибушн" ХХК гүйцэтгэж тус тус хүлээлгэн өгсөн. Дээрх худалдан авалтын үр дүнд тохижилтын байгууллагын техник, тоног төхөөрөмжийн хангалт сайжирч, цэвэрлэгээний ажлыг тасралтгүй, үр ашигтай зохион байгуулах боломж бүрдсэн.	Дорноговь

№	Хөтөл-бөрийн код	Хөтөлбөрийн нэр	Батлагдсан төсөв	Төсвийн гүйцэтгэл	Төсвийн гүйцэтгэлийн %	Хөтөлбөрийн үр дүнгийн шалгуур үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Суурь он	Суурь түвшин	2025 оны зорилгот түвшин	Хүрсэн түвшин	Тайлбар	Аймаг
26	72101	Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих	2,785,096.50	1,122,697.36	40.31%	Зорилгот хөтөлбөр ийн хэрэгжилт	хувь	2023	-	30	30.0		Дорноговь
27	72212	Гэр бүлийн хөгжил хамгаалал	945,583.30	543,813.83	57.51%	Хамрагдсан иргэдийн тоо	тоо	2023	450	600	8062.0	Гэр бүлийн гишүүдэд сэтгэл зүйн боловсрол олгох, зэрэг харилцаа хандлагыг төлөвшүүлэх зорилгоор аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар, Сайншанд сумын Засаг даргын Тамгын газар, Насан туршийн сурагцаахуйн төвтэй хамтран 52 охидод "Өсвөр насны охидын сэтгэл зүйн онцлог" сэдэвт сургалт, 10 охид зөжүүдэд "Эзгийгээ ойлго, охидоо сонсч" сэдэвтэй ээж охиод зориулсан бүлгийн сэтгэл зүйн зөвлөгөө, сургалт, "Хараацай" цэцэрлэгийн 230 эцэг эхчүүдэд "Зэрэг хичүүжлийн арга", "Хайрын хэл" сургалт, "Хөөрхөн зурх" ТББ-тай хамтран 120 эмэгтэйд "Өөрийгөө хайрлахуй" сэдэвт сэтгэл зүйн сургалт, Сайншанд сумын ИТХ-аас 50 тусгай хэрэгцээт хүүхдүүдэд зориулсан "Хамтдаа гоё" арга хэмжээг тус тус зохион байгуулж, 462 эцэг эхчүүдийг хамруулан мэргэжлийн сэтгэл зүйчид зөвлөгөө үзүүлэв. Мөн гэр бүлийн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх, ёс зүйг төлөвшүүлэх ажлын хүрээнд "Боловсрол гэр бүлээс эхэлдэг" гэр бүлийн боловсрол олгох хөтөлбөрийг аймгийн 8 баг, 14 сумын хэмжээнд хэрэгжүүлж 1100 иргэн, "Бүх хайраа гэр бүлдээ" уриа дор эцэг эх, асран хамгаалагчид болон хүүхдүүдийг хамруулсан нөлөөллийн 6 арга хэмжээг 14 суманд зохион байгуулж давхардсан тоогоор 6500 иргэнийг хамруулав. Тайлант хугацаанд хүүхэд, гэр бүлд чиглэсэн нийт 18 удаагийн сургалт, нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулж, давхардсан тоогоор 8062 иргэдийг хамруулан гэр бүлийн гишүүдийн зэрэг харилцаа хандлагыг төлөвшүүлж, сэтгэл зүйн боловсрол олгож, үүрэг хариуцлагыг нэмэгдүүлсэн.	Дорноговь
28	72201	Жендерийн тэгш байдлыг хангах	16,000.00	11,450.35	71.56%	Хамрагдсан иргэдийн тоо	тоо	2023	1500	1800	1950.0	Жендерийн хэвшмэл байдлыг халах, жендэрт суурилсан хүчирхийллийн талаар иргэдийн ойлголт, мэдлэгийг нэмэгдүүлэх чиглэлээр "Эмэгтэйчүүдийн оролцоо ба манлайлал", "Жендэр эрх тэгш байдал ба түүний үндсэн ойлголт", "Өсвөр насны хүүхэд рүү чиглэсэн үе тэнгийн дээрлэлт, электрон тамхины хэрэглээг бууруулах", "Эрэгтэйчүүдийн эрүүл мэнд", "Архины хор уршиг ба хэрэглээ" зэрэг 14 удаагийн сургалт, нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулж 1,950 гаруй иргэд, албан хаагчид хамрагдсан нь иргэдийн жендэр, жендерийн эрх тэгш байдал, салбар дундын хамтын ажиллагааг хэрхэн сайжруулах талаар мэдлэг ойлголтыг авсан. Өмнөх онтой харьцуулахад сургалтад хамрагдсан иргэдийн тоо 30 хувиар өссөн үзүүлэлттэй байна.	Дорноговь
29	72207	Хүүхдийн хөгжил, хамгаалал	1,670,000.00	1,246,514.03	74.64%	Хамрагдсан иргэдийн тоо	тоо	2023	1350	1500	16100.0	Хүүхдийн хөгжил, хамгааллын хөтөлбөр хэрэгжүүлэх зорилгоор Ерөнхий боловсролын 1,2,3,5,6 сургуулийн дэргэд сэргийлэгч хүү, зөвлөгч охины дүрээр гэрэлтэгч самбарыг байршуулж, 1-4 ангийн 3500 сурагчийн цүнхэнд гэрэл ойлгогчтой наалтыг наасан бөгөөд гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор 63 төрийн байгууллага олон нийтийн эргүүлийг хуваарийн дагуу гүйцэтгэх хэвшлээ. Мөн Сайншанд суманд тасж үйлчилгээ эрхэлж байгаа 3 компанийн 120 хөдөлгөөнд замын хөдөлгөөний дүрмийн сургалтыг зохион байгуулж, тасж үйлчилгээний стандартыг мөрдөж хэвшүүлэхийг үүрэг болгоов. Хүүхдийн хөгжил оролцоог нэмэгдүүлэх зорилгоор "Бүтээгч ирээдүйг хамтдаа бүтээх" уран илтгэл, "Хайраар дүүрэн захиа" шүлгийн тэмцээн, "Өсвөрийн парламент", "Цагаан шугам, ногоон гэрэл", "Өсвөрийн сэргийлэгч-2025", "Мини робот" өсвөрийн зохион бүтээгчдийн тэмцээн, Олон Улсын Хүүхдийн эрхийг хамгаалах өдрийн барьерын хэмжээ, "Эх орон үзэл-Үндэсний бахархал" сэдэвт эсэ бичлэгийн уралдаан, "Хамтдаа гоё" зэрэг 20 арга хэмжээнд давхардсан тоогоор 16100 гаруй хүүхдийн тэгш оролцоог ханган оролцуулав. Насанд хүрээгүй хүнийг гэмт хэрэг, зөрчил, үе тэнгийн дээрлэлтээс сэргийлэх зорилгоор "Утаат болон электрон тамхины хор уршиг", "Цахим орчны хэрэглээ", "Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эрх, аюулгүй байдал" сэдэвт сургалтыг ерөнхий боловсролын 22 сургуулийн ахлах, дунд ангийн 4500 сурагч, 1800 эцэг эх, асран хамгаалагч, Политехни коллежийн 550 оюутан, 56 багш ажилчид, 14 сумын 27 хамтарсан багийн 165 гишүүдэд, "Өөрчлөлийг өөрөөсөө" сургалтад 93 иргэнийг тус тус хамруулан зохион байгуулсан.	Дорноговь
30	72206	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжил хамгаалал	135,000.00	109,302.19	80.96%	Хамрагдсан иргэдийн тоо	тоо	2023	9	9	323.0	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн талаарх ойлголт, хандлагыг төлөвшүүлэх, нийгмийн харилцаанд оролцох тэгш эрхийг хангах зорилгоор "Халамжаас хөдөлмөрт 222" арга хэмжээний хүрээнд байнгын асаргаатай хүүхдийн асран хамгаалагч болон хөгжлийн бэрхшээлтэй 192 иргэнд, хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй 157 хүүхдийн эцэг эхэд, "Монгол Солонгосын хамтарсан шим тэжээл судлалын төв"-тэй хамтран хөгжлийн бэрхшээлтэй 20 хүүхдийн эцэг эхэд, асран хамгаалагчдад, "Хамтдаа гоё" арга хэмжээнд 40 эцэг эхийг хамруулав.	Дорноговь

**ДОРНОД АЙМАГ**

1	70105	70105 Он-ын өөрөө удирд ёсны байгууллага	4,222,942.80	3,801,376.05	90.0%	АИТХ-ын үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт	Хувь	2024	95	100	94.3	Нутгийн өөрөө удирдах байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг хангаж ажиллахад ИТХ-ын байгууллагаас 2025 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг 5 үндсэн зорилтын хүрээнд 32 арга хэмжээг төлөвлөн батлуулж хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр тооцон ажилласнаар төлөвлөгөөний биелэлт 94.3 %-ийн биелэлтэй хэрэгжсэн байна. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 03/04 дугаар тогтоолоор аймгийн иргэдийн төлөөлөгчдийн Хурлын 2025 оны төсвийг баталсан байна.	Дорнод
2	70106	70106 Он-ын гүйцэтгэх засаглалын удирдлага	50,867,487.50	44,389,955.4	87.3%	Аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт	хувь	2024	83	85	88.5	Аймгийн хөгжлийн төлөвлөгөөнд батлагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг зохион байгуулж, 2025 оны жилийн эцгийн тайлангийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийхэд 88.5 хувийн үнэлгээтэй байна.	Дорнод
3	70418	70418 Худалдан авах ажиллагаа	372,411.3	351,897.8	94.5%	Худалдан авах ажиллагааны хэрэгжилтийн үнэлгээ	хувь	2024	95	94	94.5	2025 онд Аймгийн ИТХ-ын хуралдаанаар батлагдсан нийт төсөл арга хэмжээг хуулийн хугацаанд төлөвлөж харьчлал дээд шатны төсвийн захирагчаар батлуулан хуулийн хэрэгжилтийг ханган ажилласан.	Дорнод
4	70426	70426 Төрийн өмчийн эрхийг хэрэгжүүлэх байгууллага	361,852.2	334,691.3	92.5%	ЗД-тэй байгуулсан гэрээний биелэлт	хувь	2024	85	90	93.2	Орон нутгийн өмчит байгууллагуудтай 2025 онд байгуулсан өмч эзэмшүүлэх гэрээг оны эцэст "Орон нутгийн өмчийг эзэмшүүлэх гэрээ байгуулах, дүнгээ журам"-ын дагуу орон нутгийн өмчит 116 байгууллагын гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж, үнэлж дүгнэв. Нийт 116 байгууллагын гэрээний дундаж үнэлгээ 78 үүнээс 86 байгууллага 80 хувь, 30 байгууллага 90 хувиас дээш үнэлэгдсэн байна.	Дорнод
5	70429	70429 Санхүүгийн хяналт, дотоод аудит, эрсдэлийн удирдлага	587,932.5	521,386.7	88.7%	Акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлт	Хувь	2024	79.8	81	76	Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 2025 оны жилийн хэрэгжилт 95.0 хувьтай үнэлэгдсэн. 2025 онд 67 байгууллага нэгжид хяналт шалгалт хийхээр төлөвлөснөөс төлөвлөгөөний дагуу 71 байгууллага нэгжид хяналт, шалгалтыг хийж хэрэгжилт 106%-тай. Нийт 47 акт, 77 албан шаардлага, 264 зөвлөмж өгч биелэлтийг хангуулж ажиллав.	Дорнод
6	70503	70503 Орон нутгийн зорилгот ХОруулалт	38,986,415.1	30,917,183.6	79.3%	Батлагдсан төсөл арга хэмжээний хэрэгжилтийн дундаж хувь	хувь	2024	88	95	100	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтыг аймгийн хэмжээнд холбогдох хууль, журмын хүрээнд төлөвлөн боловсруулж гүйцэтгэлийг журмын дагуу гарган ажиллалаа.	Дорнод
7	70801	70801 Мал аж ахуйг хөгжүүлэх	696,883.7	680,510.2	97.7%	Урьдчилан сэргийлэх тарилгад орон нутгийн малыг 100 хувь хамруулах	хувь	2024	100	100	100	Урьдчилан сэргийлэх тарилгад орон нутгийн малыг 100 хувь хамруулан ажилласан.	Дорнод
8	71403	71403 Ойжуулалт	420,458.7	383,704.8	91.3%	Нэмэгдүүлсэн тарьц суулгачин хэмжээ (Мянган ширхэг)	Ширхэг	2024	418,000	460,000	495000	Тайлант онд 495 мянган ширхэг тарьц суулгац тарьсан	Дорнод
9	71406	71406 Хүрээлэн буй орчны бохирдол	336,900.0	334,212.3	99.2%	Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт	хувь	2024	90	91	99.2	Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт 99.2 хувьтай.	Дорнод

№	Хөтөл-Бөрийн код	Хөтөлбөрийн нэр	Батлагдсан төсөв	Төсвийн гүйцэтгэл	Төсвийн гүйцэтгэлийн %	Хөтөлбөрийн үр дүнгийн шалгуур үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Суурь он	Суурь түвшин	2025 оны зорилтот түвшин	Хүрсэн түвшин	Тайлбар	Аймаг
10	71413	71413 Байгал орчин хамгаалан нөхөн сэргээх	2,944,421.9	2,419,246.5	82.2%	Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт	хувь	2024	88	88	78.7	Аймгийн Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар 30 ажил арга хэмжээний 2,151,936 мян төгрөгөөр гүйцэтгүүлэхээр аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 3 дугаар хуралдааны 03/04 тогтоолын 5 дугаар хавсралтаар батлуулснаас 3 ажил, арга хэмжээг тодотгоолоор хасч 28 зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласан.	Дорнод
11	71502	71502 Хот байгуулалт, тохижилт	4,998,934.4	4,940,482.0	98.8%	Төлөвлөгөөт ажил гэрээний дагуу бүрэн хэрэгжсэн байх	хувь	2024	60	60	93.2	2025 оны зорилт, арга хэмжээний хүрээнд 2,297,320.1 мян төгрөгийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд дэвшилгүйн төлөвлөгөөн зорилго, дүрмээр олгосон боловч дотоод үйл ажиллагааны зохион байгуулалт, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах чиглэлээр зорилтыг дөвшүүлсэн бөгөөд тайлант хугацаанд 93.2 хувийн гүйцэтгэлийн биелэлттэй байна.	Дорнод
13	71602	71602 Эмнэлгийн тусламж үйлчилгээ	752,896.8	696,898.1	92.6%	Ашиглалтын зардал бүрэн төлөгдөх	хувь	2024	100	100	100	Улсын төсвийн байгууллагуудын тогтмол зардлын санхүүжилтийг бүрэн олгож үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцлийг бүрдүүлэн ажилласан.	Дорнод
14	71603	71603 Эрүүл мэндийн бодлого, удирдлага	1,289,390.9	872,623.0	67.7%	Ашиглалтын зардал бүрэн төлөгдөх	хувь	2024	100	100	100	Улсын төсвийн байгууллагуудын тогтмол зардлын санхүүжилтийг бүрэн олгож үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцлийг бүрдүүлэн ажилласан.	Дорнод
15	71701	71701 Биеийн тамир спорт	263,921.5	51,632.9	19.6%	Ашиглалтын зардал бүрэн төлөгдөх	хувь	2024	100	100	100	Улсын төсвийн байгууллагуудын тогтмол зардлын санхүүжилтийг бүрэн олгож үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцлийг бүрдүүлэн ажилласан.	Дорнод
16	71702	71702 Соёл урлаг	1,218,053.9	1,040,220.4	85.4%	Ашиглалтын зардал бүрэн төлөгдөх	хувь	2024	100	100	100	Улсын төсвийн байгууллагуудын тогтмол зардлын санхүүжилтийг бүрэн олгож үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцлийг бүрдүүлэн ажилласан.	Дорнод
17	71801	71801 Сургуулийн өмнөх боловсрол	1,933,842.9	1,736,430.3	89.8%	Ашиглалтын зардал бүрэн төлөгдөх	хувь	2024	100	100	100	Улсын төсвийн байгууллагуудын тогтмол зардлын санхүүжилтийг бүрэн олгож үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцлийг бүрдүүлэн ажилласан.	Дорнод
18	71802	71802 Ерөнхий боловсрол	4,060,405.0	3,757,223.1	92.5%	Ашиглалтын зардал бүрэн төлөгдөх	хувь	2024	100	100	100	Улсын төсвийн байгууллагуудын тогтмол зардлын санхүүжилтийг бүрэн олгож үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцлийг бүрдүүлэн ажилласан.	Дорнод
19	71804	71804 Мэргэжлийн боловсрол	381,715.3	341,933.7	89.6%	Ашиглалтын зардал бүрэн төлөгдөх	хувь	2024	100	100	100	Улсын төсвийн байгууллагуудын тогтмол зардлын санхүүжилтийг бүрэн олгож үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцлийг бүрдүүлэн ажилласан.	Дорнод
20	71902	71902 Нийгмийн халамж	236,000.0	204,927.9	86.8%	Халамжийн үйлчилгээ зорилтот бүлэгт хугацаанд нь хүргэх	хувь	2024	100	100	100	Нийгмийн халамжийн тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажилласан.	Дорнод
21	72101	72101 Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих	2,119,771.6	1,139,198.5	53.7%	Төлөвлөгөөт ажил гэрээний дагуу бүрэн хэрэгжсэн байх	хувь	2024	100	100	100	Жижиг дунд үйлдвэрийг дэмжих төв ОНӨААТТ нь тайлант онд шинээр 11 ажлын байр бий болгон ажилласан.	Дорнод
		Ойжуулалт				Ойн дагалт баялаг судалгаа хийх	хувь	2024	55	70.00	60	Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар хөв цөөрөм байгуулах ажлын зураг төслийг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх ажлыг жил бүр зохион байгуулж байна. Энэ ажлын хүрээнд Баян-Өндөр сумын Харзтайн хөв цөөрмийг засварлах, Богд сумын 3 дугаар багийн нутагт орших "Баян булаг" гэх газарт хөв цөөрөм байгуулах ажлын зураг төслийг боловсруулан магадлалаар баталгаажуулан хүлээн аваад байна.	Өвөрхангай
13	71413	Байгаль орчин хамгаалах, нөхөн сэргээх	222,654.80	206,162.00	92.59%	Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт	Хувь	2024	96	100.00	98	Байгаль орчны салбарын бодлогын баримт бичиг, холбогдох эрх зүйн акт, хөтөлбөрүүдийн салбарт хамаарах зорилт арга хэмжээний биелэлтийг тухай бүр гаргаж хугацаанд нь холбогдох газруудад хүргүүлж тайлагнасан.	Өвөрхангай
						Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт	Хувь	2024	72	80.00	99.1	Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 02/12 дугаар тогтоолын 6 дугаар хэсгээр байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд 247.3 мянган төгрөгийн төсөв батлагдаж, нийт 14 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийг ханган ажиллалаа. Уг зардлаар хийгдсэн ажлын тайланг 2025 оны 11 сард аймгийн Засаг даргын зөвлөлийн хурал, Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнаж, хэрэгжилт 99.1 хувьтай дүнгэгдсэн.	Өвөрхангай
14	71502	Хот байгуулалт, тохижилт	4,795,101.20	4,767,587.51	99.43%	Хот байгуулалт, тохижилтын бодлого төлөвлөлт, хэрэгжилт зохицуулалт	Хувь	2024	97	100.00	90	Уянга суманд улсын төсвийн 6,7 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар дулаан, цэвэр усны 1 дүгээр ээлжийн 2100 метр шугам угсралт, гүний худаг гаргах, ариутгах татуургын шугамын 2 дугаар ээлжийн ажил хийгдсэн. Мөн цэвэрлэх байгууламжийн барилга угсралтын ажлын гүйцэтгэл 90 хувьтай үргэлжилж байна. Бат-Өлзий суманд улсын төсвийн 6,7 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар шугам сүлжээний угсралтын ажилд дулаан хангамжийн 1144м, ариутгах татуургын 3557м, цэвэр ус хангамжийн 3635 м шугам тус тус хийгдэж ажлын гүйцэтгэл 90 хувьтай үргэлжилж байна. Хужирт суманд Азийн хөгжлийн банкны 6,7 тэрбум, улсын төсвийн 4,3 тэрбум төгрөгийн санхүүжилтээр инженерийн шугам сүлжээний угсралтын ажил хийгдэж ашиглалтад оруулаад байна. Үүний үр дүнд тус суманд одоогийн байдлаар 22 айл өрх, 32 аж ахуйн нэгж, 3 нийтийн орон сууц цэвэр, бохирын төвлөрсөн шугам сүлжээнд холбогдсон. Цаашид бусад амралтын газар, аж ахуйн нэгж, айл өрхүүд цэвэр бохирын төвлөрсөн шугам сүлжээнд холбогдох нөхцөл бүрдсэн. "Сумын хөгжил: Инженерийн дэд бүтцийн хангамж" хөтөлбөрийн хүрээнд Нарийнтээл суманд улсын төсвийн 6,0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар шугам сүлжээний ажил гүйцэтгэж байгаа бөгөөд дулаан хангамжийн 1474м шугамын ажил хийгдэж төсөвт байгууллагын дулааны шугамыг шинэчилж, ариутгах татуургын 5200 метр, цэвэр ус хангамжийн 4147 метр шугам угсралтын ажлын гүйцэтгэл 90 хувьтай үргэлжилж байна.	Өвөрхангай
15	71602	Эмнэлгийн тусламж үйлчилгээ	3,200,276.30	2,962,765.95	92.58%	Урсгал санхүүжилтийг бүрэн олгож, үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөл боломжоор хангасан байдал.	Хувь	2024	86	100.00	100	Санхүүжилтийг гүйцэтгэлээр олгосон. Урсгал засварын зардлыг хэмнэлт	Өвөрхангай
16	71701	Биеийн тамир спорт	1,146,949.40	1,129,098.12	98.44%	Урсгал санхүүжилтийг бүрэн олгож, үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөл боломжоор хангасан байдал.	Хувь	2024	100	100.00	100	Санхүүжилтийг гүйцэтгэлээр олгосон.	Өвөрхангай
17	71702	Соёл урлаг	1,946,744.80	1,889,074.69	97.04%	Урсгал санхүүжилтийг бүрэн олгож, үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөл боломжоор хангасан байдал.	Хувь	2024	100	100.00	100	Санхүүжилтийг гүйцэтгэлээр олгосон.	Өвөрхангай
						Урсгал санхүүжилтийг бүрэн олгож, үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөл боломжоор хангасан байдал.	Хувь	2024	100	100.00	100	Санхүүжилтийг гүйцэтгэлээр олгосон.	Өвөрхангай
						Урсгал санхүүжилтийг бүрэн олгож, үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөл боломжоор хангасан байдал.	Хувь	2024	100	100.00	100	Санхүүжилтийг гүйцэтгэлээр олгосон.	Өвөрхангай
						Урсгал санхүүжилтийг бүрэн олгож, үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөл боломжоор хангасан байдал.	Хувь	2024	100	100.00	100	Санхүүжилтийг гүйцэтгэлээр олгосон.	Өвөрхангай
18	71801	Сургуулийн өмнөх боловсрол	3,074,465.60	2,764,717.77	89.93%	Урсгал санхүүжилтийг бүрэн олгож, үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөл боломжоор хангасан байдал.	Хувь	2024	94	100.00	100	Санхүүжилтийг гүйцэтгэлээр олгосон.	Өвөрхангай
19	71802	Ерөнхий боловсрол	9,757,062.80	9,398,464.39	96.32%	Урсгал санхүүжилтийг бүрэн олгож, үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөл боломжоор хангасан байдал.	Хувь	2024	96	100.00	100	Санхүүжилтийг гүйцэтгэлээр олгосон.	Өвөрхангай
20	71804	Мэргэжлийн боловсрол	1,231,399.70	1,143,625.11	92.87%	Урсгал санхүүжилтийг бүрэн олгож, үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөл боломжоор хангасан байдал.	Хувь	2024	97	100.00	100	Санхүүжилтийг гүйцэтгэлээр олгосон.	Өвөрхангай

№	Хөтөл-бөрийн код	Хөтөлбөрийн нэр	Батлагдсан төсөв	Төсвийн гүйцэтгэл	Төсвийн гүйцэтгэлийн %	Хөтөлбөрийн үр дүнгийн шалгуур үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Суурь он	Суурь түвшин	2025 оны зорилтот түвшин	Хүрсэн түвшин	Тайлбар	Аймаг
21	71807	Тусгай хэрэгцээт боловсрол	79,300.00	70,491.59	88.89%	Урсгал санхүүжилтийг бүрэн олгож, үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөл боломжоор хангасан байдал.	Хувь	2024	98.5	100.00	100	Санхүүжилтийг гүйцэтгэлээр олгосон.	Өвөрхангай
22	71902	Нийгмийн халамж	280,960.80	189,942.53	67.60%	Халамжийн сангийн зарцуулалт (зорилтот бүлэгийн тоо)	Хувь	2024	92	100.00	100	Урсгал засварын зардлыг хэмнэлтийн горимд шилжүүлж, гүйцэтгэлээр санхүүжүүлсэн.	Өвөрхангай
23	71411	Хүрээлэн буй орчны бодлого, удирдлага	1,216,931.00	1,124,401.47	92.40%	Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилт	Хувь	2024	95	100.00	100	Нэн ховор амьтан болох ирээс ихээр байршдаг Нарийнтээл сумын "Шаргын хадан" гэх газарт агнуурын бүс нутгийн менежмент хариуцагчидтай хамтран хөдөлгөөн мэдрэгч камерыг суурилуулж, нутгийн иргэдэд малаа ирээсээс хамгаалах арга болон, ирээстэй таарсан тохиолдолд авах арга хэмжээний талаарх мэдээллийг хүргэн ажиллаж байна.Агнуурын бүс нутгийн байгаль хамгаалагчид ховор ан амьтдын тархац, байршил есөлтөд байнгын ажиглалт судалгаа хийж, сумдын байгаль орчны хяналтын улсын байцаагч, нутгийн иргэдтэй хамтран 2025 онд сум орон нутгийн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар аймгийн хэмжээнд 8 суманд 560 боодол өвс 8 тонн жижир тавьж өгч 22 удаагийн биотехникийн арга хэмжээ авсан.	Өвөрхангай
24	72207	Хүүхдийн хөгжил, хамгаалал	73,051.00	53,679.00	73.48%	Үйл ажиллагааны хэрэгжилт	Хувь	2024	100	100.00	100	Хүүхэд эмэгтэйчүүдийг хамгаалах байрны ажилдын цалингийн зардалд гүйцэтгэлээр санхүүжүүлсэн.	Өвөрхангай
25	72208	Ахмад настны хөгжил хамгаалал	166,967.80	161,967.80	97.01%	Нийгмийн асрамж, халамжийн үйлчилгээг жигд хүртээмжтэй үзүүлсэн байдал	Хувь	2024	100	100.00	100	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Эрүүл мэндийн сайдын 2024 оны А/76, А/515 дугаар тушаалаар батлагдсан "Ахмад настанд цогц үнэлгээ хийх, тусламж, үйлчилгээ үзүүлэх журам"-ын дагуу асаргааны хувилбарт үйлчилгээний төндөр зарлаж "Ролгон хайрхан ХХК" гэрээр асрах үйлчилгээг зорилтот 39 ахмад настанд үзүүлж байна.	Өвөрхангай
<b>ӨМНӨГОВЬ АЙМАГ</b>													
1	70105	Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын үйл ажиллагаа	3,857,329.3	3,491,113.1	91%	Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын хуралдааныг зохион байгуулсан тоо	Тоо хэмжээ	2024	4	4	5	2025 онд аймгийн ИТХ-ын хуралдаан 5 хуралдаж, 397 заалт бүхий 132 тогтоол батлан хэрэгжүүлсэн. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлийн хурал 8 удаа хуралдсан. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөө бүрэн хэрэгжсэн буюу 92 хувьтай бүрэн хэрэгжсэн, аймгийн 2025 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилтийг 86.6 хувь, 2026 оны орон нутгийн төсвийг 2,123,157,773.4 мянган төгрөгөөр баталлаа. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас батлан гаргасан тогтоол шийдвэрийг орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах, Төлөөлөгчид гарын авлага, тогтоолын эмхэтгэл хүргүүлэх, мэдээллээр хангах арга хэмжээг 2 удаа зохион байгууллаа. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн хүрээнд 31 ажил төлөвлөн хэрэгжүүлж 87 хувь биелэлттэй ажилласан.	Өмнөговь
2	70709	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх	582,357.5	494,771.6	85%	Орон нутгийн хамгаалалтад Олон нийтийн цагдаа ажиллуулах	хувь	2024	100.0	100.0	87	Гэмт хэрэг, зөрчил, зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх, үйлдлийн илрүүлэлтийг нэмэгдүүлэх ажлыг эрчимжүүлж, тодорхой төрлийн гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан нөхцөлийг тогтоох, түүнээс урьдчилан сэргийлэх хүрээнд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас 2025 оны 4/06 дугаар тогтоолоор Гэмт хэрэг, зөрчил, зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх "Ээлтэй-Өмнөговь" хөтөлбөрийг, 4/07 дугаар тогтоолоор "Архидан соттуурах, мансууруулах бодистой тэмцэх, архинаас татгалзан иргэдийг нийгэмшүүлэх, ажлын байраар хангах хөтөлбөр, Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас 2025 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн 4/08 дүгээр тогтоолоор "Гэр бүл, хүүхэд, эмэгтэйчүүдийн хөгжил, хамгааллыг сайжруулах хөтөлбөр"-ийг баталж, аймгийн Засаг даргын Тамгын газар, Хүүхэд, гэр бүл хөгжил, хамгааллын газар, Цагдаагийн газар хамтран гэр бүл, сургуулийн орчинд хүүхдийн эрхийг хангах ажлыг эрчимжүүлэн ажиллаж байна. Гуравантэс, Ханбогд, Цогтцаций сумд болон аймгийн төвд нийт 45 олон нийтийн цагдаа ажиллуулах орон тоог батлуулан, томилон ажиллуулж байна.	Өмнөговь
			261,148,600.2	172,874,119.0	66%	"Өмнөговь аймгийг 2024-2028 онд хөгжүүлэх аймгийн Засаг даргын үйл ажиллагааны "Өсөлтэй Өмнөговь" хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах	хувь	2024	196	196	196	Агентлагийн дарга нарын шуурхай хурал танхимаар 10 удаа зохион байгуулагдсан. Мөн танхимаар Төрийн албан хаагчдыг мэргэжүүлэх, харилцаа хандлагыг сайжруулах нэгдсэн сургалт, арга хэмжээг зохион байгуулсан. АЗДТГ-ын аппаратын шуурхай 6 удаа, Халтсийн дарга нарын шуурхай 35 удаа хийж цаг үеийн нөхцөл байдалтай холбоотой мэдээ, мэдээлэл солилцсон. Засаг даргын зөвлөлийн хурал 14, Сумдын Засаг дарга нартай орон нутгийн удирдлагын өргөтгөсөн хурал цахимаар 8 удаа, Сумын Засаг дарга нарын сургалт 4 удаа зохион байгуулж, сумдын Засаг дарга нартай аймгийн Засаг даргын байгуулсан гэрээг дүгнэн ажилласан.	Өмнөговь
			4,000,000.0	1,885,038.50	47%	"Өмнөговь аймгийг 2024-2028 онд хөгжүүлэх аймгийн Засаг даргын үйл ажиллагааны "Өсөлтэй Өмнөговь" хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах	хувь	2024	89.4	96.0	91	Засаг даргын нөөц хөрөнгийг Сангийн сайдын 2018 оны 318-р тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын дагуу зарцуулж байна. Хөрөнгө зарцуулах шийдвэрийг Засаг даргын зөвлөлд танилцуулж, батлуулж, зориулалтын дагуу зарцуулдаг. 2025 онд 1885.0 сая төгрөг зарцуулсан.	Өмнөговь
			2,056,100.8	1,717,358.2	91%	Хүүхдийн зуслангийн үйл ажиллагааг хэвийн явуулж, хүүхэд өсвөр үе залуучуудын амрах, хөгжих, оролцох, чөлөөт цагаа зөв зохиистой өнгөрүүлэх хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх	Тоо хэмжээ	2024	570.0	900.0	950	2025 оны 06-р сарын 13-аас 08-р сарын 09-ний өдрийг хүртэл 7 ээлж хүлээн авч, 08-р сарын 20-оос 24-ний өдрүүдэд нэмэлт ээлж хүлээн авч нийт 976 хөгжлийн хөтөлбөр боловсруулан, Монгол ас заншил, эх орон үзлийг төлөөшүүлэх, аялалын, англи хэлний сургалттай хөтөлбөрийг хэрэгжүүлсэн. Нэлэлтээ хийсэн 20 киног үзэгчдийн хүртээл болгож давхардсан тоогоор 18452 хүнд үйлчилсэн байна	Өмнөговь
		Хүүхдийн паркийн үйл ажиллагааг эрхэлж, хүүхэд өсвөр үе залуучуудын амрах, хөгжих, оролцох, чөлөөт цагаа зөв зохиистой өнгөрүүлэх боломжийг хангах				Тоо хэмжээ	2024	0.0	2000.0	2000	Хүүхдийн паркийн бүх тоглоом болон кассын систем цахим картын системд бүрэн шилжсэн. Хүүхдийн ордон, хүүхдийн парк, Ел кино театраар үйлчлүүлсэн үйлчилгээнд хамрагдсан иргэдийн тоо давхардсан тоогоор 25000 орчим байна.	Өмнөговь	
						Хүүхдийн ордны үйл ажиллагаанд Үндэсний болон дэлхийн сонгодог хүүхдийн уран бүтээлээр үйлчилж олон нийтэд сурталчлан нийтийн хүртээл болгох	Тоо хэмжээ	2024	130.0	760.0	760	Бүтэн жилийн байдлаар 11 төрлийн дугуйлан хичээллэж давхардсан тоогоор 760 хүүхэд хамрагдсан. "Ая эгшгийн зургаан жигүүр-2025" ардын хөгжмийн наадам, "Уран жиргээ 2025" уран уншлагын аймгийн аварга шалгаруулах уралдаан, "Говийн яргуй-2025" шүлгийн уралдаан, "Алтан ураг өршөө" хүүхдийн дуулалт жүжгийн гол болон туслах дүрийн 50 гаруй хүүхэд багачууд "Хүүхдийн парад 2025"-д алхлаа. Динос ланд хүүхдийн паркийн аяллын 7 оног арга хэмжээнд хүүхдийн ордны 80 сурагчид оролцсон. Даланзадгад хот-Жонбуж муж хоорондын хамтын ажиллагааны хүрээнд зохион байгуулж байгаа Солонгос эмч нарт зориулсан бэсрэг наадамд Алтан ураг өршөө хүүхдийн жүжгийн хураангуй хувилбарыг толилуулсан. Авто тээврийн салбар үүсэж хөгжсөний 100 жилийн ойн баярт 100 хүүхдийн хүндэтгэлийн тоглолтыг өргөн барьсан. "Бидний бахархал 2025" 8 төрөлт тэмцээний нээлт болон хүндэтгэлийн тоглолт 100 хүүхдийн хүндэтгэлийн тоглолт тоглосон.Хүүхдийн ордны ахлах мэргэжилтэн Б.Төмөрбат "Маргашаа бүтээ" хувь хүний хөгжил болон тайзны соёл сургалтыг 5 удаагийн давтамжтай 100 гаруй сурагчдад зохион байгууллаа. "Хүүхэд-Хайр-Ирээдүй" хүндэтгэлийн тоглолт хүүхдийн ордны дугуйланийн нийт 150 гаруй хүүхдүүд оролцсон. Хүүхдийн байгууллага үүсэж, хөгжсөний 100 жилийн ойг зохион байгуулсан.	Өмнөговь

Орон нутгийн гүйцэтгэх

№	Хөтөл-Бөрийн код	Хөтөлбөрийн нэр	Батлагдсан төсөв	Төсвийн гүйцэтгэл	Төсвийн гүйцэтгэлийн %	Хөтөлбөрийн үр дүнгийн шалгуур үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Суурь он	Суурь түвшин	2025 оны зорилтот түвшин	Хүрсэн түвшин	Тайлбар	Аймаг
3	70106	Орон нутгийн гүндэтгэх засаглалын удирдлага	6,858,780.1	1,307,410.5	19%	"Өмнөговь аймгийг 2024-2028 онд хөгжүүлэх аймгийн Засаг даргын үйл ажиллагааны "Өсөлттэй Өмнөговь" хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах	Тоо хэмжээ	2024	17	17	17	Мал хамгаалах сан, Байгал хамгаалах сан болон сумдын нийт 15 сум хөгжүүлэх сангийн үйл ажиллагаа	Өмнөговь
			10,170,220.0	8,461,700.0	83%	"Өмнөговь аймгийг 2024-2028 онд хөгжүүлэх аймгийн Засаг даргын үйл ажиллагааны "Өсөлттэй Өмнөговь" хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах	хувь	2024	100.0	100.0	83.2	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр аймгийн ИТХ-ын төсөв баталсан тогтоолын 4-р хавсралтаар баталсан нийт 42 төсөл, арга хэмжээний 8461.7 сая төгрөгийн хэрэгжилтийн ханган ажилласан.	Өмнөговь
			211,005,859.0	163,474,385.0	77%	"Өмнөговь аймгийг 2024-2028 онд хөгжүүлэх аймгийн Засаг даргын үйл ажиллагааны "Өсөлттэй Өмнөговь" хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах	хувь	2024	100.0	100.0	77.5	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр аймгийн ИТХ-ын төсөв баталсан тогтоолын 5-р хавсралтаар баталсан нийт 300 төсөл, арга хэмжээний 163,474.4 сая төгрөгийн хэрэгжилтийн ханган ажилласан	Өмнөговь
			39,469,529.0	28,217,342.4	71%	"Өмнөговь аймгийг 2024-2028 онд хөгжүүлэх аймгийн Засаг даргын үйл ажиллагааны "Өсөлттэй Өмнөговь" хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах	хувь	2024	100.0	100.0	71.5	Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр аймгийн ИТХ-ын төсөв баталсан тогтоолын 6-р хавсралтаар баталсан нийт 116 хөтөлбөр, нэгдсэн арга хэмжээний хэрэгжилтийн ханган ажилласан	Өмнөговь
			34,200,000.0	32,222,793.7	94%	Нутгийн дэм хөтөлбөрийг хэрэгжүүлэх	Тоо хэмжээ	2024	181.0	221	227	Өмнөговь аймгийг 2024-2028 онд хөгжүүлэх аймгийн Засаг даргын үйл ажиллагааны "Өсөлттэй Өмнөговь" хөтөлбөр"-ийн 5 дугаар бүлгийн 5.1.2.9 5.1.2.10 дугаар заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2024 оны 03/13 дугаар тогтоолоор "Нутгийн дэмийн хэмжээ түүнийг олгох журам" батлагдсан. Тус журмыг үндэслэн 2025 онд 233 байгууллагын 6760 албан хаагчид 34,200.0 сая төгрөг олгохоор төсөвлөсөн. 2025 оны жилийн эцсийн байдлаар 227 байгууллагын 7158 албан хаагчид 31,924.7 сая төгрөгийн нутгийн дэм олгосон байна.	Өмнөговь
			17,300,000.0	16,053,980.5	93%	Улсын төсвийн байгууллагын албан хаагчдад олгох орон нутгийн нэмэгдлийн батлагдсан санхүүжилтийг байгууллагуудад бүрэн олгох	Тоо хэмжээ	2024	181.0	132.0	133	2025 онд Засгийн газрын 2024 оны 82 дугаар тогтоол, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоол, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2024 оны 03/08 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан Өмнөговь аймгийг 2024-2028 онд хөгжүүлэх аймгийн Засаг даргын үйл ажиллагааны "Өсөлттэй Өмнөговь" хөтөлбөрийн хүрээнд аймгийн Засаг даргын 2025 оны А/68, А/69, А/70 дугаар захирамжууд гарч орон нутгийн нэмэгдлийг олгож байна. 2025 онд орон нутгийн нэмэгдэлд 17,300.0 сая төгрөг олгохоор төсөвлөсөн жилийн эцсийн байдлаар улсын төсвийн 133 байгууллагын 4173 албан хаагчид 16,054.0 сая төгрөгийн орон нутгийн нэмэгдлийг олгосон байна.	Өмнөговь
			1,530,918,456.3	1,111,000,000.0	73%	Улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг бүрэн төвлөрүүлэх	хувь	2024	100.0	100.0	100	Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн дагуу улсын төсөвт орлого 1530.9 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс 1111.0 тэрбум төгрөг буюу 72.6 хувьтай төвлөрүүлсэн	Өмнөговь
4	70426	Төрийн өмчийн эрхийг хэрэгжүүлэх	1,181,267.0	883,423.4	75%	Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эзэмшил, хадгалалт, хамгаалалтад байгаа эд хөрөнгийн бүрэн бүтэн байдал, хэмжээг тогтоох, хөрөнгийн чанар байдал, хадгалалт, хамгаалалт, үнэлгээ, бүртгэлд үнэлэлт өгөх, хуулийн этгээдийн санхүүгийн тайлан, хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийн тайланг хүлээн авч нэгтгэх, дүн мэдээ гаргах илэрсэн зөрчлийг арилгуулах	Тоо хэмжээ	2024	38	186	186	Орон нутгийн өмчит 186 байгууллага, 74 сан нийт 260 байгууллагын санхүү, хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийн тайлан, мэдээг хянан баталгаажуулж, хуулийн хугацаанд ТӨБЗГ, ҮСХ-нд хүргүүлсэн ба аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн 7/20 дугаар тогтоолоор орон нутгийн өмчийн хөрөнгийн дүнг батлуулсан. Мөн орон нутгийн өмчит байгууллагуудад хяналтын тооллогын ажлыг зохион байгуулж, гарсан зөрчил дугаарлыг арилгуулан, хөрөнгийн ашиглалт, хадгалалт хамгаалалтад анхаарч цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар мөргөжилт арга зүйн зөвлөгөө өгч ажилласан. Улсын хэмжээнд нэгдсэн журмаар хэрэгжүүлж байгаа "Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, удирдлага зохицуулалтын цахим систем"-ийн сургалтыг 2025 оны 10 дугаар сарын 13, 14-ний өдөр ТӨБЗГ-тай хамтран төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой 242 байгууллагын дарга, өмч хамгаалах зөвлөлийн гишүүд, нягтлан бодогч, нярав гэсэн 600 гаруй албан хаагчдыг хамруулан амжилттай зохион байгуулж, заавар зөвлөмжөөр хангаж ажилласан.	Өмнөговь
5	70429	Санхүүгийн хяналт, дотоод аудит, эрсдэлийн удирдлага	490,388.9	454,542.3	91%	Санхүүгийн хяналт шалгалт хийх	Тоо хэмжээ	2024	49	1	1	Аймгийн Засаг даргын 2025 онд баталсан 47 удирдамжаар 1 байгууллагад санхүүгийн хяналт, 102 байгууллагад дотоод аудит, нийт 103 байгууллагад дотоод аудит, хяналт шалгалт хийж, 31 шалгалтын танилцуулга, 102 дотоод аудитын тайлан, ажлын баримт бичиг, зөрчилтэй ажилласан 54 байгууллагад зөрчлийг арилгуулахаар улсын ахлах байцаагчийн акт 79, 328 байгууллагад албан шаардлага 129, зөвлөмж 105 хүргүүлэн хэрэгжилтийг тооцон ажиллалаа. Нийт 51,360,483.7 мянган төгрөгийн зөрчил илрүүлснээс 739,269.7 мянган төгрөгийн акт тогтоож, 39,841,885.2 мянган төгрөгийн зөрчил арилгуулахаар хугацаатай албан шаардлага, 11,766,720.7 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж хүргүүлж, хэрэгжилтийг тооцон ажилласан. Мөн зөрчил гаргасан 23 албан тушаалтанд холбогдох хуулийн дагуу хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд саналыг хүргүүлээ. Зөрчил төлбөрийн хэрэгжилт 88.2 хувьтай байна.	Өмнөговь
						Дотоод аудит хийх	Тоо хэмжээ	2024	57	102	102		Өмнөговь
						Нөхөн төлбөр, зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилтийн хангах	хувь	2024	98	100	208		Өмнөговь
						Төсвийн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний төсвийн байгууллага, орон нутгийн өмчит аж ахуйн нэгж 189 байгууллагад Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих	Тоо хэмжээ	2024	12	12	12		Төсвийн ерөнхийлөн захирагчийн харъяа 196 байгууллагын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгаж, хяналт шалгалт болон дотоод аудит хийгдэж буй хугацааны хуулийн хэрэгжилтийг үндсэн баримттай тулган хяналт тавьж ажилласан. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт 2025 оны 11 дүгээр сарын байдлаар 23,234 мэдээлэл мэдээлэхээс 22098 мэдээлэл хугацаанд нь мэдээлсэн боловч 339 мэдээлэл хугацаа хоцроож, 808 мэдээллийг мэдээлээгүй зөрчлийг илрүүлээ. Хяналтын явцад зөрчлийг арилгуулан, нөхөж оруулж, зөвлөмжийг өгч ажилласан ба хэрэгжилт 92.6 хувьтай байна. Хуулийн хэрэгжилтийг хангалтгүй хэрэгжүүлсэн 15 сумын 156 байгууллагад 12,367,383.1 мянган төгрөгийн зөрчлийг арилгуулахаар хугацаатай албан шаардлага хүргүүлэн хэрэгжилтийг тооцож мэдээллийг оруулж ажиллалаа. Мөн зөрчил гаргасан 14 албан хаагчид хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлж, хэрэгжилтийг тооцон ажилласан.

№	Хөтөл-Бөрийн код	Хөтөлбөрийн нэр	Батлагдсан төсөв	Төсвийн гүйцэтгэл	Төсвийн гүйцэтгэлийн %	Хөтөлбөрийн үр дүнгийн шалгуур үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Суурь он	Суурь түвшин	2025 оны зорилтот түвшин	Хүрсэн түвшин	Тайлбар	Аймаг
6	70418	Худалдан авах ажиллагаа	641,551.0	598,634.2	93%	Худалдан авах ажиллагааг ил тод өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай 324 төсөл арга хэмжээний худалдан авах зохион байгуулах	Тоо хэмжээ	2024	320	324	202	Өмнөговь аймгийн ИТХ-ын 2024 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн "2025 оны төсөв батлах тухай" 3/14 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд 263.7 тэрбум төгрөгийн 325 төсөл, арга хэмжээ батлагдсан. Аймгийн 2025 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын хүрээнд тодотгоолоор 77 төсөл, арга хэмжээ нэмэгдэж нийт 270.9 тэрбум төгрөгийн 402 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулахаар төлөвлөгөөнд тусгагдсан. Батлагдсан төсөл, арга хэмжээнээс Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагын худалдан авах ажиллагаа болох 15 сум руу эрх шилжсэн 78 төсөл, арга хэмжээ байна. Жилийн эцсийн байдлаар төлөвлөгөөнд тусгагдсан 324 төсөл арга хэмжээнээс захиалагчаас техникийн тодорхойлолт, ажлын даалгавар, тоо хэмжээг батлуулан ирүүлсэн 202 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг хуульд заасан журмын дагуу www.tender.gov.mn цахим системээр нийтэд ил тод, нээлттэй зохион байгуулж, төсөл арга хэмжээний үр дүнг тухай бүр цахим системд нийтэлсэн. Амжилттай буюу гэрээ байгуулагдах эрх олгогдсон 114.9 тэрбум төгрөгийн 140 төсөл, арга хэмжээнээс бараа-34, ажил-75, зөвлөх үйлчилгээ 31 байна. Амжилтгүй болсон 62 төсөл, арга хэмжээ байна. Амжилтгүй болсон төсөл, арга хэмжээний хувьд Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13.1.1, 13.1.2, 13.1.3, 13.1.4 дэх заалтад тус тус заасны дагуу хасагдсан 17 төсөл, арга хэмжээ, оролцогчгүй, мөн тендерийн баримт бичигт заасан шаардлагыг бүрэн хангаагүй учир амжилтгүй болсон 45 төсөл, арга хэмжээ байна. Худалдан авах ажиллагаа зохион байгуулагдаагүй 122 төсөл, арга хэмжээ нь захиалагчаас ажлын даалгавар, техникийн тодорхойлолтыг батлуулж ирүүлээгүй тул зарлагдаагүй болно.	Өмнөговь
7	70503	Орон нутгийн зорилтот хөрөнгө оруулалт	66,169,133.8	46,847,143.2	71%	ИТХ-аар баталсан төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг хангах	Тоо хэмжээ	2024	16	190	184	Аймаг болон харьяа 15 сумын ОНХСангийн хэрэгжилтийг удирдлага, мэдээллийн системд бүрэн оруулсан. Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжсэн 24 төсөл арга хэмжээ, сумдын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжсэн 160 төсөл арга хэмжээний мэдээллийг оруулсан байна. Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулиар Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас 43,789.7 сая төгрөгийн орлогын шилжүүлэг хуваарилагдахаар батлагдсанаас 43,055.9 сая төгрөг хуваарилагдаж, батлагдсан дүнтэй харьцуулахад орлогын шилжүүлэг 98.3%-ийн гүйцэтгэлтэй олгогдсон байна. Үүнээс аймгийн орон нутгийн хөгжлийн санд 9,648.9 сая төгрөг, сумдын орон нутгийн хөгжлийн санд 33,407.0 сая төгрөгийн орлогын шилжүүлгийг олгож хэрэгжилтийг хангах ажиллав. Орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлгийг хуваарилахдаа Төсвийн тухай хуулийн 59 дүгээр зүйл, 60 дугаар зүйл, Засгийн газрын 2017 оны 230 дугаар тогтоолоор батлагдсан "Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон орон нутгийн хөгжлийн сангаас олгох орлогын шилжүүлгийг тооцох аргачлал", Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-ын дагуу хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох орлогын шилжүүлгийг хууль, журам зааварт нийцүүлэн аймаг болон сумдад хуваарилагдах шилжүүлгийн тооцооллыг хийж аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар батлуулж мөрдөж ажиллав.	Өмнөговь
8	71101	Авто зам	15,000,000.0	5,219,173.7	35%	ИТХ-аар баталсан төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг хангах	Тоо хэмжээ	2024	2	3	3	Замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр аймгийн ИТХ-ын төсөв баталсан тогтоолын 7-р хавсралтаар баталсан 2 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлсэн болно. "Даланзадгад Баяндалай Гурвантэс чиглэлийн авто замын засвар арчлалтад төсөв суулгасан боловч тус авто замын эвдрэл гэмтэл бага учирсан тул төсөв бага зарцуулагдсан. Мөн тус авто зам нь улсын чанартай авто замын харьяалагд орлон тул Зам тээврийн яамнаас тус авто замын засвар арчлалтыг хариуцаж "АММЗ" ХХК-аар гүйцэтгүүлсэн болно. Орон нутгийн чанартай авто замыг ашиглалтын тогтоосон хугацаанаас өмнө эвдрэл гэмтэлгүй байх нөхцөлийг хангах зорилгоор засвар арчлалт хийх ажлыг Таны зам ХХК гүйцэтгэсэн. Мөн 23-р цэцэрлэг авто зогсоол болон 3-р сургуулийн авто замын ажлууд хийгдсэн.	Өмнөговь
9	71403	Ойжуулалт	2,623,308.8	2,391,364.5	91%	Бүх нийтээр мод тарих үндэсний өдрийг холбогдох байгууллагуудтай хамтран өргөн хүрээтэй зохион байгуулах	Тоо хэмжээ	2024	330000	600000	895287	Өмнөговь Даланзадгад сумын нутаг дэвсгэрт 760 га, Булган сумын Баянзэг орчимд 1540 га нийт 2300 га талбай бүхий ойжуулалтын талбай байгуулсан. 2025 онд Өмнөговь-Ногоон хэрэм трансн дагуу Ханхонгор, Даланзадгад сумын нутаг дэвсгэр болох 12, 13-р талбайд 100 га ойн зурвас байгуулсан. Мөн Мандал-Овоо сумын Онгийн голд 2 га талбайд 1150 ширхэг бургасаар ойжуулалт хийсэн. Баяндалай сумын нутагт 10 га талбайд 15,732 ширхэг заг, хайлаас тариалан ажилласан.Өмнөговь аймгийн хэмжээнд "Тэрбум мод тарих үндэсний өдөр"-н хүрээнд нэгдсэн үйл ажиллагааг 2025 оны 04, 10 дугаар саруудад 2 удаа зохион байгуулж мод тарьсан. Аймгийн хэмжээнд 777.7 га талбайд 895,287 модыг тарьсан байна. Үүнээс - Өрх бүр жилд 9-өөс доошгүй мод тарьж ургуулах уриалгын дагуу 1,370 өрх хашаандаа 18,066 мод - Аж ахуйн нэгж, байгууллагын орчин тойронд 11 га талбайд байгуулж 22,380 мод, хуучин талбайд 9,940 нэмж тарьсан. - Нэрэмжит цэцэрлэг, баг хороонд байгуулсан бичил цэцэрлэг сад бүхий 6 хэсэгт 27.5 га талбай байгуулж шинээр 34,379 мод, хуучин талбайд 21,378 модыг нэмж - Агро ойн аж ахуйг хөгжүүлэх зорилгоор төв сууринь хамгаалалтын ойн зурвасыг 133.6 га талбайд байгуулж тус талбайд шинээр 150,053 мод, хуучин талбайд 9,600 модыг нэмж - Загаар ойжуулах ажлыг 406 га талбайд шинээр 364,000 заг, хуучин талбайд 39,630 загийг нэмж - Доройтсон ойг нөхөн сэргээх ойн зурвасыг 159.6 га талбайд шинээр байгуулж 99,890 мод, хуучин талбайд 100 модыг нэмж - Цөлжилт, газрын доройлтыг бууруулах зорилгоор баянбурд хамгаалах, нөхөн сэргээх ажлыг 10 га талбайд 32,200 модыг, хуучин талбайд 600 модыг нэмж, тариалангийн талбай байгуулах ойн зурвасыг 8 га талбайд байгуулж 3,521, хуучин талбайд 4,200 модыг нэмж, буяг шанд, хөв цөөрөм хамгаалах ажлыг 0.5 га талбайд 250, хуучин талбайд 600 модыг нэмж, авто замын хамгаалалтын ойн зурвас байгуулах ажлыг 21.5 га талбайд 82,500 мод, хуучин талбайд 2,000 модыг тус тус тарьсан байна. Тус үйл ажиллагаанд төрийн болон хувийн хөвшил, уул уурхайн чиглээр үйл ажиллагаа явуулдаг 337 аж ахуйн нэгж, байгууллага, 7,735 ажилтан, албан хаагч оролцон 3.7 тэрбум төгрөг зарцуулж мод тарьж, 82.6 хувьтай ургасан байна.	Өмнөговь

№	Хөтөл-бөрийн код	Хөтөлбөрийн нэр	Батлагдсан төсөв	Төсвийн гүйцэтгэл	Төсвийн гүйцэтгэлийн %	Хөтөлбөрийн үр дүнгийн шалгуур үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Суурь он	Суурь түвшин	2025 оны зорилтот түвшин	Хүрсэн түвшин	Тайлбар	Аймаг
						Байгаль орчны багц хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж, зөрчлийн тоо хэмжээг өмнөх онуудаас бууруулах	Тоо хэмжээ	2024	8	12	12	1. Байгаль орчныг хамгаалах, хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах олборлох гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох зорилгоор хийгдэх нэгдсэн хяналт, шалгалтын арга хэмжээний удирдамж төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий ажлын хэсгийг Аймгийн Засаг даргын 2025 оны 04 дүгээр сарын 22-ний А/485 дугаар захирамжаар байгуулж, удирдамжийг ажлын хэсгийн дарга бөгөөд бус орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого, төлөвлөлтийн хэлтсийн даргаар батлуулсан. Аймгийн Засаг даргын 2025 оны 05 дугаар сарын 29-ний А/784 дугаар захирамжын дагуу хяналт шалгалтыг тус онд 45 аж ахуйн нэгж, байгууллагад хийхээр төлөвлөж бүрэн хийж гүйцэтгэсэн. Химийн хорт болон аюултай бодис ашиглах, хадгалах, дахин боловсруулах үйл ажиллагаанд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийж тухай удирдамжийн хүрээнд 11 аж ахуй нэгжид хяналт шалгалтыг хийж аж ахуй нэгж байгууллагад 9,500,000 торгуулийн арга хэмжээ авч зөрчлийн үр дагаварыг арилгах хугацаатай албан даалгавар өгч ажилласан. Энгийн болон аюултай хог хаягдал хадгалах, ашиглах, дахин боловсруулах, устгах үйл ажиллагаанд, урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийж тухай удирдамжийн хүрээнд 29 аж ахуй нэгжид хяналт шалгалтыг хийж 58,300,000 торгууль онгоддуулж, 216,836,426 байгаль орчинд учруулсан хохирлыг тооцуулж ажилласан. Агаар бохирдуулагч аж үзвэрүүдэд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийж тухай удирдамжийн хүрээнд 23 аж ахуй нэгжид хяналт шалгалтыг хийж зөрчил гаргасан 4 аж ахуй нэгж байгууллагад 2,000,000 торгуулийн арга хэмжээ авч зөрчлийн үр дагавар арилгах хугацаатай даалгавар өгсөн. Ой, ойн дагалт баялаг, амьтан байгалийн ургамлын чиглэлээр хууль тогтоомжийн хэрэгжилтийн байдалд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийж удирдамжийн хүрээнд 5 иргэн, 15 аж ахуй нэгжид хяналт шалгалтыг хийж зөрчил гаргасан 4 иргэнд 1,200,000 торгууль, 3,280,000 нөхөн төлбөр ногдуулсан. Ус рашаан ашиглалт болон усан сан бүхий газар, хүн амын онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн дэглэмийн хэрэгжилтийн байдалд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийж тухай удирдамжийн хүрээнд 39 аж ахуй нэгжид хяналт шалгалтыг хийж 66,700,000 торгууль, 384,051,080 нөхөн төлбөр ногдуулсан бөгөөд 66,200,000 төгрөгийн торгууль төлөгдөж 1 аж ахуй нэгж байгууллагыг Нийслэлийн захиргааны хэргийн анхан шатны шүүхэд албадан гүйцэтгүүлэх хүсэлтийг явуулсан. Урьдчилан цэвэрлэх байгууламж болон ахуйн бохир усны бага овын цэвэрлэх байгууламжаас гарч байгаа хаягдал усны стандарт шаардлагыг хангуулах чиглэлээр урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийж тухай удирдамжийн хүрээнд 21 аж ахуй нэгжид шинжилгээтэй хяналт шалгалтыг хийж гүйцэтгэсэн.	Өмнөговь
						Байгаль хамгаалах төрийн болон төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулах	Тоо хэмжээ	2024	3	6	6	Байгаль зэрлэг амьтныг хамгаалах нийгэмлэг /WCS/-тэй хамтран "Байгалийн нөөцийн хамтыг менежментийн төлөвлөлт, орон нутгийн оролцоо" зөвлөлдөх уулзалтыг Баяндалай, Хүрмэн, Номгон сумдын байгаль хамгаалах нөхөрлөлийн дунд 2025 оны 5 сард зохион байгуулсан. Сургалтад 4 нөхөрлөлийн 58 иргэн оролцов. Хүрмэн суманд байгалийн нөөцийн хамтын менежментийн чиглэлээр шинээр 2 нөхөрлөл байгуулагдаж сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар батлуулан гэрчилгээг олгон мэргэжил аргагүйн зөвлөгөө өгсөн.	Өмнөговь
						Байгаль хамгааллын сургалт, нөлөөллийн арга хэмжээг олон нийтэд хүргэх	Тоо хэмжээ	2024	3	4	0	Байгаль орчныг хамгаалах нөлөөллийн ажлын хүрээнд "Өсвөрийн байгаль хамгаалагч" сургалтыг 5 сард төлөвлөсөн боловч аймгийн Боловсролын газраас "Хичээлийн жилийн үнэлгээ хийхтэй холбогдуулан хүүхдэд чиглэсэн аливаа арга хэмжээг зохион байгуулахгүй байх талаар хамтран ажиллах тухай" албан бичигтэй холбоотой сургалтыг 2025 оны 7 дугаар сард зохион байгуулахаар хойшуулсан. Гэвч Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу төсөв зарцуулалт 05 дугаар сарын 31-ний өдрөөр зогссон учир тухайн арга хэмжээг зохион байгуулах боломжгүй болсон.	Өмнөговь
						Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах	Тоо хэмжээ	2024	43	50	50	Байгалийн нөөц ашигласны төлбөрийн /усны/ 2025 оны орлого /19 тэрбум төгрөг/-ийн 35-аас дээш хувь, Байгаль хамгаалах сангаас 9.6 тэрбум, орон нутгийн төсвөөс 11.5 тэрбум, нийт 21.1 тэрбум төгрөгийг аймгийн ИТХ-аар "Байгаль хамгаалах чиглэлийн хөрөнгөөр 2025 онд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний зардал"-д тусган батлуулж 14 тэрбум төгрөгийг зарцуулсан байна. Сумдад ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлогын 50 хувийг Байгаль хамгаалах арга хэмжээний зардалд зарцуулах чиглэлийг БОГ-гаар болон АЗДТ-гаарын СТСХэлтсээс чиглэл хүргүүлж хяналт тавин ажиллаж байна. Байгалийн нөөц ашиглагчийн мэдээлэл, бүртгэлийн санг үүсгэх ажлын хүрээнд тус онд Цогт-Овоо, Баяндалай суманд амьтны нөөц ашиглах менежмент хариуцагчаар 2 аж ахуйн нэгж, байгууллагыг, мөн усны нөөц ашиглагч 8 аж ахуйн нэгж, байгууллагад ус ашиглах дүгнэлт гаргаж мэдээллийн санд бүртгэсэн. Аюултай хог хаягдал үүсгэгчээр 5 аж ахуйн нэгж, байгууллагыг бүртгэн www.eis.mn цахим мэдээллийн санд бүртгэж дугаар олгосон. 15 сумын хэмжээнд байгалийн нөөц ашиглагчийн мэдээллийн бүртгэл үүсгэсэн ажиллаж байна.	Өмнөговь
						Байгаль орчны салбарын боловсон хүчнийг чадавхижуулах, ажиллах нөхцөл бололцоогоор хангах	Тоо хэмжээ	2024	2	4	4	2025 оны 01 дүгээр сарын 17-ний өдөр сумдын Байгаль хамгаалагч, Байгаль орчны хяналтын улсын байцаагч, мэргэжилтэн нарт Төрийн жинхэнэ албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, тайлагнах, Төрийн хяналт шалгалтын тухай хууль болон Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн нийтлэг журмыг хэрэгжүүлэх, цаашид анхаарах асуудлын хүрээнд сургалтыг 28 албан хаагчдын дунд зохион байгуулсан. 2025 оны 03 дугаар сарын 28-ний өдрөөс 29-ний өдрүүдэд Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль болон Зөрчлийн тухай хуулийг хэрэгжүүлэх хүрээнд гарч буй зөрчил анхаарах асуудлын хүрээнд байцаагчийн эрхтэй Байгаль хамгаалагч болон Байгаль орчны хяналтын улсын байцаагч 9 албан хаагчдад онлайн-ар сургалт орсон. 2025 оны 05 дугаар сарын 27-ний өдөр Төрийн хяналт шалгалт хийх нийтлэг журмын хүрээнд "Төлөвлөгөөт бус хяналт шалгалтын удирдамж" боловсруулах, анхаарах асуудлын хүрээнд байцаагчийн эрхтэй Байгаль хамгаалагч болон Байгаль орчны хяналтын улсын байцаагч 9 албан хаагчдад онлайнаар сургалт орсон. 1. Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох 2. 3 дугаар үе шатын хүрээнд Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамнаас Байгаль орчны хяналтын улсын байцаагч болон Байгаль хамгаалагч нарт 26.2 сая төгрөгийн үнийн дүнтэй 9 нэр төрлийн 126 ширхэг хувцас, техник тоног төхөөрөмжөөр хангаж дэмжлэг үзүүлсэн. Байгаль орчны газрын 19 албан хаагчдын ажлын хэрэгцээнд зориулан орон нутгийн төсвийн 3,420,000 төгрөгөөр гутал, малгай болон холбогдох хувцас хэрэгслээр хангасан. Албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөний эхний хагас жилийн тайланг хүлээн авч үнэлж, дүгнэх ажлыг зохион байгуулж 20 албан хаагч "Хангалттай сайн" үнэлэгдэж 10,378,500 төгрөгийн мөнгөн урамшуулал олгогдсон байна.	Өмнөговь

№	Хөтөл-бөрийн код	Хөтөлбөрийн нэр	Батлагдсан төсөв	Төсвийн гүйцэтгэл	Төсвийн гүйцэтгэлийн %	Хөтөлбөрийн үр дүнгийн шалгуур үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Суурь он	Суурь түвшин	2025 оны зорилгот түвшин	Хүрсэн түвшин	Тайлбар	Аймаг
10	71411	Хүрээлэн буй орчны бодлого, удирдлага	1,737,755.9	1,602,434.2	91%	Хүрээлэн буй орчны тэнцвэрт байдлыг хангах, Орчны бохирдлыг бууруулах, Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, бохирдол багатай ногоон хөгжлийн бодлогын хэрэгжилтийг хангах	Тоо хэмжээ	2024	9	12	12	PET Хяядал хуванцар хаягдал угаах, бутлах автомат ажиллагаатай иж бүрэн төхөөрөмж худалдан авах ажлыг орон нутгийн төсвийн 1.0 тэрбум төгрөгөөр гүйцэтгүүлэхээр тендерийг 4 сард зарлах гомдол гарсан. Мөн төрийн хэмнэлтийн тухай хуулиар худалдан авах ажиллагааг 2025 оны 5 сарын 31-ний өдрөөр зогсоосон тул 2026 оны төсөвт суулгаж хийж хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Аймгийн хэмжээнд хоёрдогч түүхий эд худалдан авдаг иргэн аж ахуй нэгжийг дэмжих зорилгоор сэрээт өргөгч 1, пресслэгч 1, бутлагч 1, портер автомашин 1, нийт 4 ширхэг тоног төхөөрөмж нийлүүлэх тендер 05 сард зарлаж оролцогч компаниуд шаардлага хангаагүйгээс тендер дахин зарласан боловч төрийн хэмнэлтийн тухай хуулиар худалдан авах ажиллагааг 2025 оны 5 сарын 31-ний өдрөөр зогсоосон. Даланзадгад сумын Захирагчийн ажлын алба томоохон үйлчилгээний төвүүдэд үүссэн хаягдал кардонон цаасыг эх үүсвэр дээр нь ангилан ялгаж эдийн засгийн эргэлтэд оруулах ажлыг зохион байгуулж 10 тонн хаягдал цаасыг дахин боловсруулах үйлдвэрт нийлүүлсэн. Дэлхийн усны өдрийг 2025 оны 3 сарын 22-ны өдөр "Мөнх цас-Месен голоо хамгаалаа" уриан дор тэмдэглэн, тус өдрийн хүрээнд төрийн байгууллагуудын дунд гар бөмбөг, хүүхдүүдийн дунд ширээний теннисийн тэмцээн, булаг шанд цэвэрлэгээ, цахим фостерийн уралдаан тэмцээн зохион байгуулсан. Гар бөмбөгийн тэмцээнд 22 байгууллагын 132 тамирчин, теннисийн тэмцээнд 5 насны ангилалаар нийт 7 сумын 200 хүүхэд хамрагдаж 64 хүүхэд байр эзэлсэн. Мөн Говийн бүсийн аймгууд болох Өмнөговь, Говьсүмбэр, Дорноговь аймгуудын иргэдийн дунд цахим постерийн уралдааныг 1 сарын хугацаатай зарлаж бүтээлүүдийг хүлээн авч Дундговь аймгийн Өндөршил сумын ЕБСургуулийн 9а ангийн сурагч Усаа хайлаа, Усны үнэ цэнэ сэдэвт бүтээл ирүүлж 1-р байр эзэлсэн. Аймгийн хэмжээнд ЕБСургуулийн сурагчдын дунд "Булагаа хамгаалаа" сэдвийн хүрээнд булаг шандны эхийг цэвэрлэх уралдаан зохион байгуулж Баяндалай сумын ЕБС, Цогтцэций сумын 1, 2 сургуулийн 11-р ангийн сурагчид, Ноён сумын ЕБС, Даланзадгад сумын 1-р сургуулийн сурагчид сум орон нутагтаа байрлах нийт 9 булаг, шандны эхийг 28 га талбайг цэвэрлэсэн байна. ОНТ 15 сая төгрөг зарцуулсан. Тэрбум мод үндэсний өдрийн хүрээнд мод тарих үйл ажиллагааг 2025 оны 04, 10 дугаар сард 2 удаа зохион байгуулж 835,287 мод тарьсан. 3.7 тэрбум төгрөгийн зардал гаргасан байна. Дэлхийн нүүдлийн шувуудыг ажилгах өдрийн хүрээнд "Зэргэцэн амьдрая хамтран оршихуй" уриан дор цахим мэдээлэл хэрэгсэлээр мэдээлэл өгч ажилласан. Олон улсын эх дэлхийн өдрийг 2025 оны 04 дүгээр сарын 22-ний өдөр "Бидний хүч бидний гарал" уриан дор байгалийн нөхөн сэргээх, хамгаалахад хүмүүсийн өдөр тутмын гүйцэтгэх үүргийг онцлон сануулах зорилготойгоор тэмдэглэн өнгөрүүлсэн. 5. Дэлхийн ойн өдөр "Ой ба хүнс" хүрээнд тэмдэглэн өнгөрүүлсэн бөгөөд 500 ширхэг гарын авлага бэлтгэн хэвлэн тарааж, цахим хэрэгсэлээр мэдээлэл түгээн ажилласан.	Өмнөговь
						Газар /хөрс/, газрын хэвлийг хамгаалах, нөхөн сэргээх	Тоо хэмжээ	2023	4	4	4	Ханбогд сумаас Дэмчигийн хийд хүртэлх хатуу хучилттай авто замын бүтээн байгуулалтын ажилд ашигласан эвдрэлд орж оргилсон 11 га талбайн техникийн нөхөн сэргээлтийг хийлгэж актаар баталгаажуулан хүлээн авсан. Номгон сумын элстэй Бор толгой, Сэжүүл гэх газарт 10 га талбай нөхөн сэргээх ажлыг Саусгоби сандс ХХК өөрийн хөрөнгөөр гүйцэтгэж хүлээлгэн өгсөн. Гурвантэс суманд Өсөх зоос ХХК өөрийн хөрөнгөөр 3 га талбайд нөхөн сэргээлт хийж хүлээлгэн өгсөн.. Натур консалтинг мэргэжлийн байгууллагатай 16.5 сая төгрөгийн шууд гэрээ байгуулж Цогтцэций суманд 3 хэсэг газарт Байгаль орчинд учруулсан хохиролыг тооцуулсан. Нийт 3 суманд 24 га талбайд нөхөн сэргээлт хийсэн. Байгаль орчинд хохирол учруулсан 4 аж ахуй нэгж, байгууллагад 174.3 сая төгрөгийн хохирлыг тооцож ажилласан.	Өмнөговь
						Биологийн төрөл зүйл /олон янз байдал/ - ийг хамгаалах, менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах	Тоо хэмжээ	2023	7	13	13	"Биологийн олон янз байдлын олон улсын өдөр"-ийг тохиолдуулан "Монголын говийн биологийн олон янз байдал" форумыг 2025 оны 5 дугаар сарын 29-ний өдөр Өмнөговь аймгийн Даланзадгад хотод зохион байгуулсан. Энэ удаагийн форумыг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам, "Өнө мөнхийн Монгол" хөтөлбөр, Өмнөговь аймгийн Засаг даргын тамгын газар, Байгаль орчны газар, Монголын ан агнуурын холбоо хамтран зохион байгуулсан бөгөөд Өмнөговь, Дорноговь, Говьсүмбэр, Өвөрхангай, Дундговь аймгийн байгаль орчны мэргэжилтэн, байгаль хамгаалагч, Тусгай хамгаалалттай газар нутгийн дарга, мэргэжилтнүүд, аж ахуйн нэг байгууллага, ТББ-ын төлөөллүүд 200 гаруй хүн оролцсон. Форумд оролцогчид орон нутгийн тулгамдсан асуудлуудаа илэн далангүй ярилцаж, харилцан туршлага солилцон, санал хүсэлтээ нэгтгэж, төрийн бодлого шийдвэрт тусгуулахаар Байгаль орчин уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ц.Уртнасанд гардуулан өгсөн. Биологийн олон янз байдал, нэн ховор, ховор амьтан, ургамлыг хамгаалах зорилгоор 2025 оны 10 дугаар сарын 03-ны өдөр "Цөлжилтийн эсрэг-ногоон ирээдүй" олон улсын эрдэм шинжилгээний бага хурлыг Оюутолгой ХХК-тай хамтран зохион байгуулсан. Хуралд Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны сайд Б.Батбаатар, УИХ-ын гишүүн Р.Сэддорж, Л.Мөнхбаясгалан болон аймгийн удирдлагууд, говийн бүсийн аймгуудын төлөөлөл оролцож цөлжилтийн талаар судалгаа хийсэн. 5 оны 70 гаруй эрдэмтний эрдэм шинжилгээний бүтээлүүд танилцуулж 4 аймгийн 185 төлөөлөгч оролцсон. Өмнөговь аймгийн "Хар сүүл" хамгааллын менежментийн төлөвлөгөөг аймгийн ИТХ-ын 2024 оны 9 сарын 18-ний өдрийн 19/22 тогтоолоор 8 зорилтын хүрээнд 62 арга хэмжээг төлөвлөн батлуулж, 2025 онд 5 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Үүнд: Шинэчлэгээ холбоо ТББ-тай хамтран хар сүүлийг олон нийтэд таниулах арга хэмжээний 1 нэвтрүүлэг, 5 контентиг бүтээлэн хүлээн авч нийтэд түгээн ажиллаж байна. Хар сүүлийг дүрийг бүтээн хар сүүл зээрийг олонд сурталчлах, хамгаалах арга хэмжээг таниулах богино хэмжээний 36 цахим бичлэг хийхээр иргэн Б.Ган-Очир, Х.Сувд-Эрдэнэ, М.Гонгор нартай гэрээ байгуулан гүйцэтгүүлж байгууллагын пэйж хуудсаар дамжуулан олон нийтэд түгээн ажиллаж байна. "Зэрлэг амьтныг хайрлан хамгаалаа"-Зэргэцэн амьдрал уриан дор Скай говь фитнес клубтай хамтран Амьтны тухай хууль тогтоомжийг сурталчлах, олон нийтэд таниулах арга хэмжээг 2025 оны 11 сарын 29-ний өдөр Даланзадгад суманд зохион байгуулсан. Тус өдөрлөт Аргал янгиур хамгаалах сан, Зэрлэг амьтан услах ТББ, ГГБЦГ-ын захиргаа хууль сурталчилж, мэдээлэл өгч ажилласан.. Байгаль хамгаалах нөхөрлөлүүдийг чадавхижуулах сурталгыг Хүрмэн суманд шинээр байгуулагдсан 2 нөхөрлөлд зохион байгуулж, сумын хурлаар оруулж гэрчилгээг олгуулсан. Зэрлэг амьтан авран хамгаалах ус төрийн бүт байгууллагатай 12.2 сая төгрөгийн шууд гэрээ байгуулж Ноён, Баяндалай, Хүрмэн сумын 4 уст цэгийг сэргээн засварлан ашиглагтад оруулж, 13 худаас дата мэдээлэл цуглуулан боловсруулж хүлээлгэн өгсөн.	Өмнөговь

№	Хөтөл-бөрийн код	Хөтөлбөрийн нэр	Батлагдсан төсөв	Төсвийн гүйцэтгэл	Төсвийн гүйцэтгэлийн %	Хөтөлбөрийн үр дүнийн шалгуур үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Суурь он	Суурь түвшин	2025 оны зорилгот түвшин	Хүрсэн түвшин	Тайлбар	Аймаг
						Усны нөөцийг бохирдол, хомтлоос сэргийлэх нэгдсэн менежментийг хэрэгжүүлж, баталгаат ундны усаар хангасан хүн амыг 80 хувьд хүргэх	Тоо хэмжээ	2024	19	23	23	Усны нөөцийг бохирдолоос сэргийлэх ажлын хүрээнд усан сан бүхий газрын хамгаалалтын бүсийн дагльмийг мөрдүүлж, тэмдэгжүүлэх ажлыг 9 суманд 50 ширхэг анхааруулга самбар байршуулах ажлыг орон нутгийн төсвийн 132.0 сая төгрөгөөр "Хос өрөөл инженеринг" ХХК гүйцэтгэн ашиглаж байгууллага болох сумын ЗДТГазарт хүлээлгэн өгсөн. Булаг шанд хамгаалах ажлын хүрээнд Баяндалай, Булган, Ноён, Сэврэй, Хүрмэн Ханхонгор сумдад тус бүр 1, нийт 6 булаг шандын эхийг хашиж хамгаалах, булгийн ундаргын ажиглалт хийх ажлыг орон нутгийн төсвөөр зохион байгуулахаар худалдан авах ажиллагааг зарласан боловч амжилтгүй болж гэрээ хийгээгүй.Номгон сумын Ботт багийн нутагт Баянбулгийн эх /200м/ -ийг хашиж хамгаалах ажлыг аймгийн Засаг даргын 2025 оны А/99 дүгээр захирамжаар сумын Засаг даргад эрх шилжүүлэн, гүйцэтгэгчээр "Говийн лхам" ХХК шалгарч орон нутгийн төсвийн 216.0 сая төгрөгөөр гүйцэтгэж хүлээлгэн өгсөн. Хүрмэн сумын Давст булгийн эхийн 420 м2 талбайг хашиж хамгаалах ажлын гүйцэтгэгчээр Их залаат хайрхан ХХК шалгарч орон нутгийн төсвийн 124.3 сая төгрөгөөр гүйцэтгэсэн. Ноён сумын Ганзагад булгийн эхийн 120 м2 талбайг хашиж хамгаалах, хөв цөөрөм байгуулах ажлын гүйцэтгэгчээр "Хишиг Юниверс" ХХК шалгарч орон нутгийн төсвийн 56.0 сая төгрөгөөр, Цогтцэций сумын Сийрст багийн нутагт байршилтай Сайн бичигтийн задгай булгийн эхийн 510 м2 талбайг Энержи ресурс компани 10.0 сая төгрөгөөр, Гурвантас сумын Баясах багийн нутагт байршилтай Бумбаа булгийн эхийн 25 м2 талбайг Хүрэн толгой гуулд майнинг компани 2.0 сая төгрөгөөр, Гурвантас сумын Баясах багийн нутагт байршилтай Довын булгийн эхийн 100 м2 талбайг Баатарван транс компани 3.0 сая төгрөгөөр, Цогтцэций сумын Сийрст багийн нутагт байршилтай Хэрэйн булгийн Зүүн булгийн 216 м2 талбайг Эрдэнэ таван толгой компани 5.0 сая төгрөгөөр тус тус хашиж хамгаалсан. Ажиллалт судалгааны чиглэлээр: Баян-Овоо, Ханхонгор, Сэврэй, Гурвантас, Ханбогд суманд нийт 6 булгийн эхэд ундаргын ажиглалт хийж, чанарын хэмжилтийг сар бүрийн эхийг 7 хоногт багтаан хийж дата мэдээлэл цуглуулах ажлыг Байгаль орчны газар, Сав газрын захиргаад хамтран зохион байгуулж байна.	Өмнөговь
